



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.05.20, ДАВАА ~ №094 (1146)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Хяналтын хорооны түргэдсэн шийдвэр УИХ, Удирдах зөвлөл дээр бүдрэв

Ш.Раднаасэд, Д.Дамба-Очир нарт таван жил улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй гэв. >2

Машины импортыг АНУ-ын үндэсний аюулгүй байдалтай холбов

Машины тарифыг гадаад, дотоодын үйлдвэрлэгчдийн аль аль нь эсэргүүцэж байна. >9

Шил үйлдвэрлэлд шинэ боломж нуугдаж байна

Шил, шилэн эдлэлийн импорт даган багагүй хэмжээний валют хилийн чанад руу урсаж байна. >12


FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхийлөгч Х.Баттулга бизнесийнхэнтэй чөлөөт ярилцлага хийжээ.
Нэр бүхий долоон хүнийг Элчин сайдаар томилох шийдвэрийг Засгийн газар гаргав.
Г.Батхүү агсны амь насаа алдсантай холбогдуулан АН ажлын хэсэг байгуулжээ.
Ш.Раднаасэд, Д.Дамба-Очир нарт тооцсон хариуцлагыг УИХ дахь бүлэг, УЗ дэмжсэнгүй.

ЭДИЙН ЗАСАГ
"Мон-Ит Булигар" компани хувьцааныхаа 86 хувийг 2.2 тэрбум төгрөгөөр арилжлаа.
"Жуулчин дютти фри" шинэ буудалд салбараа нээнэ.
ОХУ-ын эрчим хүчний бус экспорт энэ онд 160 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй.
Топ 20 индекс 0.29 хувиар өсөж, 20246.63 нэгжид хүрсэн байна.



НИЙГЭМ
Автомашингүй өдрийг сард нэг удаа зохион байгуулахыг иргэд хотын захирагчаас хүсчээ.
Ватиканы нууц архивт байсан Монголын түүхийн баримт бичгүүдийг эх орондоо авчирна.
Налайхын замын ажил эхэлсэн тэй холбогдуулан Улаанбаатар-Баян чиглэлд Рэйлбус аялж эхэллээ.
Нөөцийн махны өргөтгөсөн худалдааг амралтын өдрүүдэд зохион байгуулав.

ДЭЛХИЙ
Австралийн Ерөнхий сайд С.Моррисоны тэргүүлсэн эрх барилгч нам яллаа.
Беларус руу хоолойгоор нийлүүлдэг нефть бохирдсон учрыг ОХУ тайлбарлана.
Ливийн нийслэл рүү давшилт зогссон үед Засгийн газарт зэвсгийн тусламж иржээ.
Брекситийн улмаас Британийн фермерүүд улирлын ажилчин хөлслөхөд хүндрэл гарав.
Швейцарт татварын шинэчлэл ба галт зэвсгийн хяналтын асуудлаар санал асуулга боллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.05.20

18° | 1°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРС УНШИНА УУ.

8 658 000 029 112 0 1145

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©



Хотын төвийн, улсдаа шилдэгт тооцогдох 1 болон 23 дугаар сургуулийн хүүхдүүдээс сүрьеэгийн халдвар илэрсэн гэх шинэ мэдээлэл сонсогдох болов. С.Батсайхан / ЗГМӨ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН Сүм барьж сум хөгжүүлэх тэнэглэлд автжээ

Г.Билгүүн ЗГМ

Сумын буйдхан төвд ганц нэг машин, мотоцикл, дэлгүүрийн үүд сахисан халамцуу нөхдийг эс тооцвол жилийн гурван улиралд хөл хөдөлгөөн бараг үгүй. Харин амьдрал зогссон мэт эл хульхан сумын төвд наадам дөхөхөөр л зорчих хөдөлгөөн илт сэргэдэг. Ялангуяа, тэгш ой тохиосон зун бүтээн байгуулалтын ажил өрнөж эмнэлэг, сургуулийн хашаа хайсыг шинэчлэх, "холбоо, хонтоор, хөлөөв" гурвыг тойрсон

будаг шохойны ажил ундарна. Зочин угтах хаалганаас эхлээд зочид буудал, хүндэтгэлийн гэр, дурсгалын хөшөө бэлтгэх гээд дарга, даамлын хариуцаж авсан ажил ч мундахгүй. Нийслэлд ирж хандив цуглуулах, нэр хүндтэй хүмүүсээ урих, мөнгө амласан дээдсээ мөшгөх гээд утсаа улайстал, хөлөө удлтал хөөцөлдөх ажил бүр дундрахгүй. Харин тэр цугласан мөнгийг хэрхэн зарцуулж, сум орноо өөд татсанаа баярынхаа өдрүүдээр "тайлагнадаг" юм.

> 5

KING TOWER
 LUXURY APARTMENT & PENTHOUSE

KING TOWER АПАРТМЕНТ-ЫН ЗАХИАЛАГЧ БҮРД ИТАЛИЙН PENSARECASA БРЭНДИЙН ХҮҮХДИЙН ӨРӨӨНИЙ ТАВИЛГА БЭЛЭГЛЭЖ БАЙНА

Франц архитекторын зураг төслийн дагуу Герман инженерийн хяналтаар баригдсан **KING TOWER** апартаментын бүрэн шинэчлэгдсэн, шинэ төлөвлөлттэй орон сууцаас онгон нэрлэсэн үнээр гэрээ хийсэн эрхэм захиалагч бүрдээ **Итали улсын PENSARECASA брэндийн хүүхдийн өрөөний иж бүрэн тавилга бэлэглэх БЭЛЭГТЭЙ УРАМШУУЛАЛ зарлалаа.** **Италийн PENSARECASA брэндийн 100% Норвеги улсын ой модоор хийгдсэн,** усан суурьтай өнгөлгөөний технологийг ашигладаг учраас нярайн биед харшлах бодисгүй, **хүүхдийн эрүүл өсөн торних нөхцлийг дээд зэргээр хангасан,** динамик чадвар буюу хувирах үйлдэлтэй, **Европын дизайны шагналыг удаа дараа хүртэж байсан** зэрэг олон давуу талтай хүүхийн өрөөний иж бүрэн тавилгыг **KING TOWER апартаментын нэрлэсэн үнээр гэрээ хийж буй шинэ захиалагчдадаа бэлэг болгон өгч байна.**

Мэдээлэл авах утас:
88887063, 99250462

ЭМГЭНЭЛ



Гаваагийн БАТХҮҮ (1960-2019)

Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын Их Хурлын тусгай хяналтын дэд хорооны дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн Газрын гишүүн, сайд асан, АН-ын дэд дарга Гаваагийн Батхүү 2019 оны 05 дугаар сарын 17-нд зуурдаар таалал төгслөө.

Гаваагийн Батхүү нь 1960 оны 05 сарын 19-нд Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрж, Өвөрхангай аймгийн 10 жилийн дунд сургууль, 1983 онд ЗХУ-ын Харьков хотын инженер-эдийн засгийн дээд сургууль, докторант, 1999 онд ШУТИС-ийн бизнесийн удирдлагын магистр цол хамгаалжээ.

Г.Батхүү нь төр, нийгмийн зүтгэлтэн байлаа. Г.Батхүү нь Авто засварын заводын засварчнаас хөдөлмөрийн гараагаа эхлүүлж, тээврийн салбарын бодлого тодорхойлох хэмжээнд хүртэл ажилласан бөгөөд улмаар Монгол Улсын Их Хурлын гишүүнээр гурван удаа сонгогдож, Засгийн Газрын гишүүн Дэд бүтцийн хөгжлийн сайд, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, УИХ-ын дэд даргаар томилогдон ажиллаж, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хөгжилд тод томруун үл мөрөө үлдээсэн. Түүний санаачилж батлуулсан олон хууль, дүрэм, журам өнөөдөр УИХ, Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж, дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, боловсрол, хөдөө аж ахуйн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсаар байна.

Г.Батхүү нь манлайлагчдын нэг байлаа. Г.Батхүү нь ардчилсан шинэ Үндсэн хуулиар

хамгаалагдсан хувийн хэвшлийг бий болгох, хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж үндэсний компанийг үүсгэн байгуулсан нь Монгол Улсын тэргүүлэгч компанийн нэг "Шунхлай" групп болон өргөжөөд байна. Тэрээр эрхэлсэн ажилдаа эзний ёсоор ханддаг байсан бөгөөд олон улсын стандартуудыг нутагшуулах, шинэ техник технологийг нэвтрүүлэх, менежмент, маркетингийн дэвшилтэт хэлбэрүүдийг анхан нэвтрүүлэгчдийн нэг байлаа.

Г.Батхүү нь олонтойгоо хамт, олныхоо удирдагч нь, олноороо хүрээлүүлсэн хүн байлаа.

Г.Батхүү нь МоАН санаачлага, Ардчилсан залуучуудын холбоо, Монголын баг сумдын үндэсний холбоог үүсгэн байгуулж Монгол-Солонгосын эдийн засгийн форум, Монголын морин спорт уяачдын холбоо, Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо, Монголын автомашин мотоциклын спортын холбооны Ерөнхийлөгч, дарга, удирдах байгууллагад удаа дараа сонгогдон ажиллаж иржээ. Тэр найз нөхдийнхөө, хамт олныхоо өмөг түшиг нь, тулгуур багана нь, сайн зөвлөгч, санаа тавигч нь байнга байсан юм.

Г.Батхүү нь Монгол үндэстний өв соёл, Монгол ахуй, уламжлалыг сэргээн дэлгэрүүлэгч, соёлын зүтгэлтэн байлаа.

Г.Батхүү нь нүүдэлчний соёл, ахуйг орчин үеийн хөгжил дэвшилтэй холбох, Монгол малын гарал угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх судалгаа, практикийн олон ажлыг санаачлан эхлүүлж хэрэгжүүлсэн юм. Түүний уясан "Толин хул"-аар өнгөлүүлсэн олон хурдан морьд Монгол түмнээ олон жил баясаж, наадмын айраг түрүүг олонтаа авч ирсэн билээ. Монгол түмний их баяр цэнгэл наадмыг түүний зохиосон "Толин хул" дуугүйгээр төсөөлшгүй бөгөөд "Сүүтэй зүүдэн", "Хужирт нутаг" зэрэг олон дуулах дуртай олон дууны үгийг зохиожээ.

Төр бүлийнхээ зүтгэлтэн, төрийн бус байгууллагуудын тэргүүн, үндэсний өв соёлоо эрхэмлэн дээдлэгч Г.Батхүүгийн хөдөлмөр зүтгэлийг Монгол Улсын төр засаг өндөрөөр үнэлж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Монгол Улсын "Тод манлай" уяач цолоор шагнажээ.

Гэр бүлийнхээ халамжит хань, үр хүүхдийнхээ хайртай аав, ах, анд нөхдийнхөө түшиг тулгуур, халамжлан хүмүүжүүлэгч, амьдралын ноён нуруу болсон хүмүүний бадрангүй гэгээн дүр төрх, үйлс бидний сэтгэл зүрхэнд мөнхөд үлдэнэ.

Түүний хэлэх дуртай "Эргэж уулзах нүүртэй амьдрах сайхан..." гэдэг үгийг бид сэтгэл зүрхэндээ үүрд тээж явах болно.

"ШУНХЛАЙ ГРУПП"

АЛТ 1275 0.82%	ЗЭС 6056 0.72%	10-ЧИНГИС БОНД 98.700 0.13%	ХУРАЛДАЙ БОНД 110.70 0.12%	ГЭРЭГЭ БОНД 99.330 0.12%	АМ.ДОЛЛАР 2,646.21	ЮАНЬ 382.84	РУБЛЬ 40.96
-----------------------------	-----------------------------	--	---	---------------------------------------	------------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

НАМУУД



Хяналтын хорооны түргэдсэн шийдвэр УИХ, Удирдах зөвлөл дээр бүдрэв



С.Батбаян / ЗГМ ©

Ш.Раднаасуд, Д.Дамба-Очир нарт таван жил улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй гэв

Б.Энхжаргал
@enkhjirgizgm

МАН-ын Хяналтын ерөнхий хорооноос УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир, Ш.Раднаасуд нарт хариуцлага тооцож, таван жилийн хугацаанд улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй байх

шийдвэр гаргасан. Ш.Раднаасудийг Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг таван жил болгох санал гаргасан гэдэг үндэслэлээр хариуцлага тооцсон бол Д.Дамба-Очир “Оюутолгой” компанид хийсэн шалгалтын дүнг парламентаар хэлэлцэхээс өмнө “Рио-Тинто”-д хүргүүлсэн гэдгээр буруудаж байгаа юм. Нам улс төрийн дэмжлэг үзүүлэхгүй гэдэг нь дээрх хоёр гишүүнд 2020 оны сонгуульд нэр дэвших мандат олгохгүй гэсэн үг. Тэгвэл Хяналтын ерөнхий хорооны дээрх шийдвэрийг УИХ дахь МАН-ын бүлэг хэлэлцсэн байна. Тэгэхдээ гишүүдийн олонх нь намын

Хяналтын хорооны шийдвэрийг буруутгажээ.

УИХ-ын гишүүн хэлсэн үгэндээ хариуцлага хүлээх ёсгүй гэж үзжээ

Энэ талаар тус бүлгийн дарга Д.Тогтохсүрэнгээс тодруулахад “Хяналтын ерөнхий хорооны шийдвэрийг буруу гэж үзэж байна.

УИХ-ын гишүүн нэгдсэн чуулган болон байнгын хорооны хуралдаан дээр үг хэлж, байр сууриа илэрхийлэх нь чөлөөтэй. “Оюутолгой” компанид Д.Дамба-Очир гишүүн бичиг өгсөн нь хууль зөрчөөгүй үйлдэл. Үүний төлөө хариуцлага хүлээлгэж болохгүй. Тиймээс намын хяналтын байгууллагад хүсэлт гаргаж, дахин хуралдаж, энэ асуудлаа дахин хэлэлцэх хүсэлт өгсөн. Хууль, хяналтын байгууллага шалгаж тогтоогоогүй асуудлаар ийм хурдан шийдвэр гаргаж, гишүүдийн эрх ашгийг хөндөж болохгүй. УИХ-ын гишүүнийг байр сууриа илэрхийлснийх нь төлөө, байнгын хорооны даргыг албан бичиг явуулсных нь төлөө

шийтгээд байвал цаашид гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж чадах уу. Зүгээр нэг хэвлэлээр гарсан зүйлээс болж арга хэмжээ аваад байвал энэ 64 гишүүн дотор арга хэмжээ авахуулахгүй хүн олдохгүй. Ер нь бүлгийн гишүүд энэ шийдвэрийг эсэргүүцэж байгаа” гэв. Тэгэхдээ МАН-ын дүрмэнд Хяналтын ерөнхий хорооны шийдвэрийг Удирдах зөвлөлөөр хэлэлцэх ёстой гэж байдаг. Энэ дагуу хуралдсан намын Удирдах зөвлөл Хяналтын хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх боломжгүй гэж үзжээ. Учир нь УИХ-ын гишүүн хэлсэн үгэндээ хариуцлага хүлээх ёсгүй гэж үзсэн байна. [ЗГМ]

АН үзэл баримтлалаа орон даяар танилцуулна

Ардчилсан нам үзэл баримтлалаа орон даяар сурталчлан таниулах зорилгоор үндэсний хэмжээний аяныг эхлүүлж байна. Аяны нээлтийг өнгөрсөн баасан гарагт зохион байгуулсан бөгөөд УИХ-ын гишүүн, Ардчилсан намын дарга С.Эрдэнэ, дэд дарга З.Нарантуяа, Б.Дэлгэрмаа, нийслэлийн АН-ын дарга Д.Баттулга нарын хүмүүс оролцож, аяны талаарх мэдээлэл өгсөн юм.

Ардчилсан намын суурь зарчим, тулгуур бодлого болох үзэл баримтлалыг орон даяар сурталчлах аян 21 аймаг, нийслэлийн есөн дүүрэгт болно. Аяны хүрээнд тус намын удирдлагууд өнгөрсөн долоо хоногт зүүн аймгуудад ажиллаж, гишүүд дэмжигчидтэйгээ уулзаж, санал бодлыг нь сонссон юм. Үзэл баримтлалаа танилцуулах аян ирэх өдрүүдэд говийн аймгуудад үргэлжлэх аж. [ЗГМ]



УЛААНБААТАР

С.Амарсайхан: Яармагийн бүтээн байгуулалт төлөвлөгөөтэй уялдаж ёстой

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан холбогдох албаныхантай уулзаж, бүтээн байгуулалтын ажлуудыг түргэвчлэх үүрэг, чиглэл өглөө. Түүнчлэн Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөвлөгөөг холбогдох газруудтай хэлэлцсэн

аж. Үүгээр Яармагийн шинэ төлөвлөлтөд ямар асуудал тулгамдаж байгааг, бүтээн байгуулалтыг хэрхэн урагшлуулах тухай ярилцжээ. Хотын Захирагч С.Амарсайхан “Улаанбаатар хотын жишиг төлөвлөлт ямар байхыг Яармагийн шинэ бүтээн байгуулалтаар үлгэрлэн харуулах болно. Тиймээс салбарын яамдтай хамтран шийдэх

шаардлагатай асуудлаа яаралтай шийдэж, ажлаа явуулах хэрэгтэй байна. Яамнаас олгосон газар гээд хотын ерөнхий төлөвлөлттэй уялдахгүй байж таарахгүй. Ирэх долоо хоногт хотын удирдлагууд Яармагт ажиллаж, нөхцөл байдалтай танилцана. Хот төлөвлөлтийн бодлогыг зөрчөөд байвал тусгай зөвшөөрөлтэй нь ярина” хэмээн анхаарууллаа. [ЗГМ]

ЭШЛЭЛ



“Оюутолгой”-н гэрээтэй холбоотой асуудлыг УИХ-ын Ажлын хэсэг шалгаж, Эдийн засгийн байнгын хороогоор нээлттэй хэлэлцүүлнэ. Нууц задруулсан эсэх талаар ТЕГ дүгнэлт өгөх байх. Төр, ард түмний эрх ашгийг дээдэлж ажиллах ёстой УИХ-ын гишүүний үйлдэлтэй холбогдуулан намын Хяналтын хороо ёс зүйн дүгнэлт гаргах ёсгүй. Асуудал байвал УИХ-ын Ёс зүйн хороо, хууль хяналтын байгууллага холбогдох шийдвэр гаргах ёстой.

УИХ-ын дарга Г.Занданшатар

ЗГМ ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ
Ерөнхийлөгч Х.Баттулга энэ сарын 13-ны өдөр “Шинэ эдийн засгийн форум”-д оролцож үг хэлэх үеэрээ бизнесийн салбарынхантай ойрын хугацаанд уулзаж, чөлөөт ярилцлага өрнүүлнэ гэсэн билээ. Энэ дагуу тэрбээр Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд бизнесийн салбарт тэргүүлэгч 200 орчим бизнес эрхлэгчтэй зангиагүй уулзалт зохион байгуулж, чөлөөт ярилцлага өрнүүлжээ.

» ТОМИЛГОО
Нэр бүхий долоон хүнийг Элчин сайдаар томилох шийдвэрийг Засгийн газраас гаргалаа. Тодруулбал Б.Доржийг Польш, Ж.Сэрээжавыг Лаос, Ш.Батцэцэгийг Куба, Н.Анхбаярыг Австрали, Т.Жанабазарыг Швед, Д.Даваасүрэнг Солонгост суух Элчин сайдаар тус тус томилсон бол, В.Энхболдыг НҮБ-ын дэргэд суух байнгын төлөөлөгчөөр илгээхээр болов.

» ТӨСӨЛ
“Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газар эгүүлэн татахаар болов. Үүнд МИАТ, Хөрөнгийн Бирж, Төрийн банк гэх мэт томоохон төрийн өмчит компаниудыг хувьчлахаар тусгасан байв.

» ХАРИЛЦАА
“Гэмт этгээд шилжүүлэх тухай” Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс хоорондын гэрээний төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороотой зөвшилцөхөөр болов. Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар Монгол Улсад БНСВУ-ын хоёр иргэн ял эдэлж байгаа бол тус улсад ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн байхгүй байна.

» ТОО

914
Зөвшөөрөл. 2016 оны байдлаар 54 байгууллага 914 төрлийн зөвшөөрөл олгож байна. Монгол Улсын хэмжээнд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл буюу тодорхой үйл ажиллагааг эрхлэхээр эрх олгосон, тэдгээртэй холбоотой нэгдсэн мэдээллийн сан байхгүй бөгөөд зөвшөөрөл олгож буй нэгж бүр мэдээллийн дэд сан үүсгэдэг аж.

ЭМГЭНЭЛ



ГАВААГИЙН БАТХҮҮ
(1960-2019)

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Дэд дарга, Засгийн Газрын гишүүн асан Ардчилсан Намын Дэд дарга, төр нийгмийн зүтгэлтэн, бидний эрхэм дотны нөхөр Гаваагийн Батхүү цаг бусаар хорвоогийн мөнх бусыг үзүүлж түүний гэр бүл, журмын нөхөд, Монголын ардчилалд хүнд гарз тохиолоо. Энэхүү эмгэнэлт мэдээг Ардчилсан Намын мянга мянган гишүүд, ардчиллын үйл хэрэгт мөр зэрэгцэн зүтгэж явсан журмын анд нөхөд нь цочирдон хүлээн авч, гүнээ эмгэнэн гашуудаж байна. Гаваагийн Батхүү нь Өвөрхангай аймагт төрж өссөн, хуучнаар ЗХУ-ын Харьков хотод инженер эдийн засагч мэргэжил эзэмшин, Авто засварын заводын жирийн засварчнаас ажлын гараагаа эхэлж, мастер, хэлтсийн дарга, Тээврийн Яамны ахлах мэргэжилтэн, Дэд бүтцийн хөгжийн яаманд газрын дарга, улмаар Дэд бүтцийн хөгжлийн сайд хүртлээ дэвшин ажилласан, салбарынхаа шилдэг боловсон хүчин, манлайлагч байлаа. Тэрээр улс орон зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй байсан нийгэм эдийн засгийн хүнд үед дэд бүтцийн салбарыг тэргүүлэх хугацаандаа авто зам, зам тээвэр, иргэний нисэх, аялал жуулчлалын салбарт эрс шинэчлэлийн шинжтэй, Монгол Улсын хөгжилд хожмоо үнэтэй хувь нэмэр болсон бодлого шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байсан юм. Г.Батхүү нь 2004, 2008, 2012 онуудад төрөлх Өвөрхангай аймгаасаа Улсын Их Хуралд Ардчилсан Намаас нэр дэвшин, ард түмнийхээ итгэлийг хүлээн Улсын Их Хурлын гишүүнээр гурвантаа сонгогдон, мөн Улсын Их Хурлын дэд дарга, УИХ-ын Тусгай хяналтын дэд хорооны даргаар тус тус сонгогдон ажиллаж байв. Улсын Их Хурлын гишүүн, Дэд даргаар ажиллах хугацаандаа тэрээр олон арван хууль санаачлан батлуулж, ард түмний төрд төлөөлж ажиллаж чадсан Монгол Төрийн итгэлт түшээ байлаа. Г.Батхүү нь Монгол Улсад өрсөрсөн ардчиллын үйл хэргийг анхнаас нь дэмжин оролцож, үзэл санаандаа бат тууштай зогсч, ардчиллын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйлсэд бүхий л ухамсарт амьдралаа зориулсан бидний журмын анд байлаа. 2000 онд Ардчиллын төлөөх таван намын нэгдлийн үр дүнд байгуулагдсан Ардчилсан Залуучуудын холбооны анхны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллахаар ардчилсан үзэл санааны туг дор нэгдсэн мянга мянган залуусын үлгэр дуурайлал болж чадсан юм. Монголын ардчилалд сорил тулгарсан байсан түүхэн цаг үед Түүний манлайлал, залуусын дунд ардчилсан үзэл санааны шинэ давалгааг бий болгож, намын бүхэл бүтэн шинэ үеийг өсгөж бойжуулсан юм. Түүнчлэн

намын анхан болон дунд шатны байгууллагыг орон нутагт бэхжүүлэхэд ямар ч цаг үед биечлэн үлгэрлэн оролцож, бүх талаар дэмжин ажиллаж байсан нь Ардчилсан Намын хөгжил бэхжилтэнд томоохон хувь нэмэр болж байв. Тэрээр Ардчилсан Намын Гүйцэтгэх Зөвлөл, Улс төрийн зөвлөл, Үндэсний Зөвлөлдөх Хороо, Үндэсний Бодлогын хорооны гишүүнээр өнөөг хүртэл ажиллахаар намын үзэл баримтлал, дүрэм, мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын шинэ чанартай суурь бичиг баримтыг боловсруулах үйлсэд байнга оролцож, монголын улстөрийн тэргүүлэх хүчин болсон Ардчилсан Намыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан улстөрч байв. Г.Батхүү нь төр, улстөрийн нөр их ажлынхаа зэрэгцээ Монголын Автотээвэрчдийн Нэгдсэн Холбоо, Монголын Автомашин Мотоциклийн Спортын Холбоо, Монголын Төмөрлөг Машин Үйлдвэрлэгчдийн Холбоо, Монголын Баг Сумдын Үндэсний Холбоо зэрэг мэргэжлийн болон олон нийтийн байгууллагуудыг үүсгэн байгуулж, тэргүүнээр нь ажиллаж байв. Тэрээр залуус, олон нийтийг мэргэжил сонирхлынхоо дагуу нэгдэж, өсөж дэвжихэд байнга дэмжлэг үзүүлдэг, нийгэм олон нийтийн нэрт зүтгэлтэн байлаа. Г.Батхүүгийн үүсгэн байгуулалцсан “Шунхлай” групп, “АПУ” ХК-иуд нь олон мянган ажлын байр бий болгож, тэргүүлэх технологийг нэвтрүүлж, хувийн хэвшлийн салбарт ямагт манлайлагч байсаар ирсэн төдийгүй нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч төсөв бүрдүүлэгч, манлай татвар төлөгч Монгол Улсын шилдэг аж ахуйн нэгжүүд болсон нь түүний хөдөлмөр зүтгэлтэй салшгүй холбоотой. Гаваагийн Батхүү нь олон мянган журмын нөхөд бидний дунд үзэл санаандаа тууштай байх, төрийн ажилд хоёргүй сэтгэлээр үнэнчээр зүтгэх, эхлүүлсэн ажлаа үлгэр жишээ хийж гүйцэтгэх зан чанараараа ямагт үлгэр дуурайлал болдог байв. Тэрээр ямар ч үед эгэл, энгийн зан чанартай, хүний төлөө гэсэн халуун сэтгэлтэй, уул шиг нөмөр нөөлөгтэй анд нөхөр маань байв. Монголын ард түмний хайртай хүү, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчиллын үзэгч оод, Ардчилсан Намын Дэд дарга Гаваагийн Батхүүгийн хийж бүтээсэн үйл хэрэг, нөхөрсөг сайхан зан чанар бидний сэтгэл зүрхэнд үүрд хадгалагдан үлдэх болно.


АРДЧИЛСАН НАМ
2019.05.20

Цаг үе

100 мянган хүн ам тутам дахь сүрьеэгийн өвчлөл

757

Жил бүр
4000
хүн шинээр
өвчилж байна



Улсын хэмжээнд сүрьеэ өвчнөөр

2018 онд **228**

2017 онд **219**

2016 онд **274**

хүн нас барсан

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага ©

Таны хүүхэд өнөөдөр сүрьеэгийн халдвартай гэртээ ирэх вий

Хотын төвийн сургуулиудад хүртэл сүрьеэгийн халдвар тархсан гэх мэдээлэл байна

Б.Энхжин
ЗГМ

“Халдвар авсан болгон сүрьеэгээр өвчилсөн гэсэн үг биш. Нийт халдвар авсан хүмүүсийн 10 орчим хувь нь л өвддөг” хэмээн албан тушаалтнууд хариуцлагаас мултграхаар тайвшруулах зуур сүрьеэгийн сэжигтэй тохиолдлууд улам газар авч байна. Анх 15 дугаар сургуулийн 500 гаруй хүүхэд сүрьеэгийн халдвар авч, тэдний 38 нь өвчилсөн мэдээлэл ил болсноор энэ өвчин олны анхаарлын төвд орсон. Араас нь 97 дугаар сургуулийн 70 гаруй сурагч халдвар авсан нь тогтоогдсон бол Төв аймгийн Сүмбэр суманд 200 гаруй хүүхэд халдвар авсны зургаа нь өвчилсөн мэдээлэл олныг цочирдуулсан билээ. Гэтэл хотын төвийн, улсдаа шилдэгт тооцогдох 1 болон 23 дугаар сургуулийн хүүхдүүдээс сүрьеэгийн халдвар илэрсэн гэх дуулиан сонсогдох боллоо. Хэрэв энэ мэдээлэл үнэн бол энэ өвчний тархалт үнэхээр үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд очжээ гэсэн үг.

Сайн сургуулийн үзүүлэлтүүдийг бид эдгээр сургуулиар жишээ болгон авдаг. Зөвхөн сургалт, сурагчдын амжилтаас гадна цэвэр цэмцгэр байдал, тохижилт, тоног хэрэгслийн тал дээр манайдаа л шилдэгт тооцогддог. Хэрэв сайн бүхний жишиг болсон шилдэг сургуулиас сүрьеэгийн халдвар илэрсэн бол бусад нь яах болж байна аа. Тоос шороондоо дарагдсан хотын захын сургуулиудын талаар яриад ч хэрэггүй болох нь.

Энэ жил ерөнхий боловсролын 90 гаруй сургуулийг сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамруулахаар төлөвлөж буйгаа ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт, судалгааны албаны дарга Д.Энхмандах тайлбарласан. Одоогоор энэ ажил 50 гаруй хувьтай яваа. Сургуулиудыг шинжилгээнд бүрэн хамруулаагүй, дүн мэдээлэл нэгдсэн байдлаар ирээгүй ч мянга шахам хүүхэд сүрьеэгийн халдвар авсан нь хэдийн тогтоогдчихлоо. Муу амлахыг хүсэхгүй байгаа ч энэ тоо цаашид улам нэмэгдэх нь тодорхой. Тиймээс бид нэг хэсэгтээ, магадгүй хэдэн жилийн

турш сүрьеэгийн талаарх муу мэдээ сонсох нь ойлгомжтой боллоо.

Дорвитой тэмцэхгүй бол сүрьеэг хяналтаасаа алдаж эхэллээ

Засгийн газар өнгөрсөн баасан гарагт ээлжит бусаар хуралдаж, энэ үеэр Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл сүрьеэ өвчний үзлэг шинжилгээний талаар танилцуулав. Улмаар цаашид үзлэг шинжилгээг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай

тоног төхөөрөмжийг судалж, зардлыг нь шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгажээ.

“Энэ сарын 16-ны байдлаар 25 сургууль, нэг цэцэрлэгийн 6932 сурагч, ажилтныг үзлэг, шинжилгээнд оруулж, өвчилсөн 47 сурагч, багшийг эмчилгээнд хамруулаад байна.

Цаашид сургууль, цэцэрлэгийн нягтралыг бууруулах, шинээр барих болон одоо байгаа сургуулийн агааржуулалтад анхаарах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн агуулга, чанарыг сайжруулах, багш, ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт чанартай, бүрэн хамруулж хяналт тавих нь зүйтэй гэж үзэж байна” хэмээн Засгийн газрын албан мэдээнд дурджээ.

Энэ өвчний дэгдэлтэд засгийн

зүгээс анхаарлаа хандуулж, арга хэмжээ авахаар шийдсэн нь сайн хэрэг. Гэхдээ л ниргэсэн хойно нь хашхирдаг монголчуудын зан энэ удаад ч давтагдав. Үүнийг хэлэхэд эмч нар, мэргэжлийн хүмүүс сүрьеэгийн тархалт өндөр байгааг хэдэн жилийн турш анхааруулж, сануулсаар ирсэн. Гэтэл төрийн томчууд энэ үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөснийхөө горьг одоо амсаж байна. Тэр ч байтугай ХӨСҮТ-ийнхөн үзлэг шинжилгээ хийхдээ “Глобал” санг царайчлан, дэмжлэг авч буйгаа хэлж байна лээ. Улс мөнгөө харамлаад хөдөлж өгөөгүй ажилд төрийн бус байгууллагын туслалцаа авч байгаа нь дэндүү өрөвдөлтэй. Харин хүүхдүүд хэдэн зуугаараа халдвар авсны дараа засаг төр нь арайхийж анхаарлаа хандуулах нь бодохоос гутмаар үйлдэл.

● 15 дугаар сургуулиас эхэлсэн дуулианаар сүрьеэгийн тархалт ямар аюултай хэмжээнд хүрснийг мэдэж авлаа.

● Энэ жил ерөнхий боловсролын 90 гаруй сургуулийг сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамруулахаар төлөвлөж байгаа.

● Харамсалтай нь сүрьеэ тархах бүх л таатай нөхцөл нь Монголд, тэр тусмаа Улаанбаатарт бүрэлдчихээд байна.


Тун удахгүй сурагчдын амралт эхлэх гэж байна. Анги танхимдаа сүрьеэгийн халдвар авсан, түүнийгээ мэдээгүй хүүхдүүд зуны гурван сарын турш хөдөөгүүр амарна, зусланд явна. Энэ хэрээр энэ чимээгүй тахлын тархалт хүрээгээ улам тэлэх нь ойлгомжтой. Нөгөө талаар сургуулиудад хийж буй үзлэг шинжилгээ амралт эхлэхтэй зэрэгцэн зогсох нь тодорхой. Харин есдүгээр сард сургууль дахин орох үед ажлын эрчим буурч, олон нийт тоохоо больсон цагт сүрьеэгээр Монгол дэлхийн шившиг болох вий. Бид юмыг мартагдаа амархан улс шүү дээ. Тиймээс сургууль амрахаас өмнө энэ хэд хоногт хүн хүчээ сайн дайчилж, үзлэгийн цар хүрээг өргөжүүлээч, эрхэм сайд аа. Сүрьеэ илэрсэн л бол нууж хаагаад байлгүй нээлттэй мэдээлж, сэрэмжлүүлэх нь зөв шүү. 15 дугаар сургууль дээр хүүхдүүд сүрьеэгээр өвдсөн байна гэх мэдээ бүтэн жилийн өмнө цацагдахад сургуулийн удирдлагууд худал хэмээн мэлээж, бүр хүүхэд амиа алдсан байхад бидний нэр хүндийг унагалаа хэмээн шүүхэд хандсан талаар бид өмнөх дугаартаа нийтэлсэн. Энэ мэтээр халдварын тохиолдлыг нуугаад байвал өвчин намжих биш хүрээгээ улам тэлнэ.

Сүрьеэг ядуусын өвчин гэж ярьдаг. Дархлаа муу, бие султай бол сүрьеэгээр өвчлөх магадлал өндөр. Мөн ойр ойрхон ханиад хүрэх нь уушгийг гэмтээж, цаашлаад сүрьеэ болох эрсдэлтэй. Харамсалтай нь сүрьеэ тархах бүхий л таатай нөхцөл нь Монголд, тэр тусмаа Улаанбаатарт бүрэлдчихээд байна. Өвлийн хэдэн сарын турш нүүрсний хорт утаагаар амьсгалсан хүмүүсийн уушги эрүүл байх ямар ч үндэсгүй. Ялангуяа, бага насны хүүхдүүд энэ их утаанд хамгийн их хордож байгаа. Өвлийн цагт эмнэлгүүд ханиад нь хүндэрсэн хүүхдээр дүүрдэг нь үүний нотолгоо. Арайхийж өвлийн их утааг давж гарлаа гэхэд хаврын тоос шороо залгаад утгана. Тэгээд дээрээс нь нийт хүн амын гуравны нэг нь энэ ядуу гэх ангилалд багтаж, энэ арми өдрөөс өдөрт хүрээгээ тэлж байна. Ганц кг мах авч дийлэхгүй байгаа хүмүүс үр хүүхдээ шим тэжээлтэй хоолоор тэжээж чадах уу. Түүнчлэн сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муугаас нэг ангид тавь, жараараа хичээллэж буй сургууль олон байна. Тэр олон хүүхэд ганц ангид умгар чихлэхдээр агаарын солилцоо явагдахгүй нь хэнд ч ойлгомжтой. Ийм байхад бид сүрьеэгийн тархалтаар дэлхийд эхний тавд орохоос ч аргагүй.

Сүрьеэ өвчин одоо л гэнэт дэгдээд, хүүхдүүдэд халдварлаад байгаа юм биш. Харин үзлэг шинжилгээг нэгдсэн байдлаар хийсний ачаар нуугдмал, далд байсан тохиолдлуудыг гаргаж ирж байгаа хэрэг. Тиймээс одоо ид яригдаж, хүмүүсийн халаглаж шогшроод байгаа халдвартай хүүхдийн тоо юу ч биш. Цаашид энэ байтугай дэгдэж Монголыг аалзны тор шиг нөмрөх цаг айсуу. Нуун дарагдуулчихгүй бол шүү дээ.

Хорт хавдар аюулын харанга дэлдэж буй талаар бид шуугиж, төр засгийн зүгээс хавдрыг бууруулах чиглэлээр ажил хийж байгаа. Тэгвэл сүрьеэ өвчний дэгдэлтэд ч бас онцгойлон анхаарч, үндэсний хэмжээний аян өрнүүлэх цаг болсон юм биш үү. Энэ өвчний улмаас Монголд жил бүр 200 гаруй хүн нас барсаар байна. Тухайлбал, 2018 онд 228, 2017 онд 219 хүн, 2016 онд бүр 274 хүн сүрьеэ өвчний улмаас хорвоог орхилоо. Энэ бол бага тоо биш. Үүнээс гадна өвчилсөн хүмүүсийн эмчилгээнд ямар их мөнгө зарцуулж, эдийн засгийн хувьд ямар их дарамттай нүүр тулж байгааг бодоод нэг үзээрэй. Монголчууд бид “сохорсон биш завшив” гэж ярьдаг. Тэгвэл 15 дугаар сургуулиас эхэлсэн дуулианаар сүрьеэгийн тархалт ямар аюултай хэмжээнд хүрснийг мэдэж авлаа. Энэ өвчний дэгдэлтэд энгийн иргэдээсээ эхлээд төр засгийн хэмжээнд анхаарлаа хандуулах цаг иржээ. Сүрьеэгийн эсрэг хийх “дайн”-ыг улам өргөжүүлж, хүн хүчээрээ тэмц л дээ. Одоо л хүч хаяхгүй бол сүрьеэг хяналтнаасаа алдах эрсдэл нэгэнт бий болсныг санахад илүүдэхгүй биз ээ. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



Мөнгөний урсгал

UBER-ИЙН НУУЦ “АЛТНЫ УУРХАЙ”

Uber Eats энэ жил толгой компанийнхаа орлогын 10 хувийг бүрдүүлэх төлөвтэй байгааг хөрөнгө оруулагчид таатай хүлээн авч байна. Гэхдээ хөрөнгө сайтай томоохон өрсөлдөгчид ижил төрлийн үйлчилгээг хэдийн нэвтрүүлээд эхэлжээ.



Uber Eats-ийн захирал Жейсон Дроге хоол, хүнснийхээ 18 хувийг Eatsаппликэйшнээр захиалж авдаг

Uber 2008 онд анх хөрөнгө оруулагчдад такси үйлчилгээнийхээ төлөвлөгөөг танилцуулж байхдаа хүргэлтийн үйлчилгээгээр нэмэлт орлого бүрдүүлэх боломжтойг дуулгаж байв. Гэтэл өдгөө хүргэлтийн үйлчилгээ өндөр ашигтай бизнес болоод байна. Компанийн гүйцэтгэх захирал Дара Хосровшахигийн тооцоолсноор Uber Eats 2019 онд дэлхий дахинд 10 тэрбум ам.доллартай дүйцэхүйц (2018 онд зургаан тэрбум ам.доллар) хоол, хүнсний хүргэлт хийх аж. Uber захиалгын тооцооноос 30 хувийн шимтгэл авч, жолооч нарт хүргэлтийн төлбөр төлдөг. Өөрөөр хэлбэл, 2019 онд Uber Eats-т дор хаяж нэг тэрбум ам.долларын орлоготой ажиллах боломж бий. Энэ нь Uber Eats хоол хүргэлтийн үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгчдийн эгнээнд багтаж, АНУ-д Grubhub-ийн (2018 оны орлого нэг тэрбум ам.доллар орчим) дараа хоёрдугаарт, Caviar, Postmates, DoorDash-ын өмнө эрэмбэлэгдэж буйг илэрхийлнэ.



Uber-ийн гүйцэтгэх захирал Дара Хосровшахи Uber Eats-ийн үйл ажиллагааг Дрогед даатгажээ. Дроге “Үнэнийг хэлэхэд би бизнесийн ертөнцөд хамгийн доогуур үнэлэгддэг ажил хийдэг” гэв.

Францискогийн энэхүү компани 2018 оны наймдугаар сард санхүүжилт татахдаа 76 тэрбум орчим ам.доллараар үнэлэгдэж байсан ба хөрөнгө оруулагчид 2019 оны сүүлчээр төлөвлөгөө буй IPO-ийн ачаар компанийн үнэлгээ 120 тэрбум ам.долларт хүрнэ хэмээн үзэж байна. Гол асуудал нь Uber-ийн үндсэн бизнес болох таксины үйлчилгээ нь энэ үнэлгээг хангаж чадахгүйд оршино. Компанийн өсөлт саарах хандлагатай байгаагаас гадна олон улсад таксины бизнес хумигдаж буй тул Uber Хятад дахь үйл ажиллагаагаа энэ бүс дэх өрсөлдөгч Didi Chuxing компанид Зүүн Өмнөд Азийн бизнесийгээ хамт 2016 оны наймдугаар сард худалдсан юм. Мөн 2018 оны гуравдугаар сард Uber-ийн жолоочгүй машин явган зорчигч дайрч аминд нь хүрсэн ноцтой хэрэг гарсан тул нэг үе зардал бууруулах шийдэл хэмээн үзэж байсан энэ бизнесийнхээ туршилтыг тэд зогсоож, ажилчдаа чөлөөлжээ. Иймээс тэд одоо хөрөнгө оруулагчдад яагаад Lyft-ийг үйлчилгээгээр нь хуваахаар ДУЛАМХОРЛОО

“Намайг анх Uber-т нэгдэж байх үед компанийн үндсэн үйл ажиллагаа такси үйлчилгээнд төвлөрч байлаа. Харин Eats туслах бизнест тооцогдож байсан” хэмээн 2017 оны наймдугаар сараас хойш гүйцэтгэх захирлын алба хашиж буй Хосровшахи өгүүлэв. Хэдий өргөжин тэлж буй ч Uber Eats их хэмжээний алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд хэзээ ашигт ажиллагаанд хүрэхийг Хосровшахи өөрөө ч хэлж мэдэхгүй байна. Тиймээс Uber-ийн хөрөнгө оруулагчид “Хүнс хүргэлтийн үйлчилгээ ирээдүйд ашиг авчрах уу, алдагдалд хүргэх үү” гэсэн асуултын өмнө ирээд байна.

Энэ нөхцөл байдал 2014 онд Uber Eats-ийг үүсгэн байгуулагдсанаас нь хойш удирдаж буй, өдгөө 40 настай Жейсон Дрогед хэзээний танил санагдана. Uber-ийн хуучин гүйцэтгэх захирал Трэвис Каланикийн шавь тэрбээр Uber-ийн анхны хөрөнгө оруулагчдаас томоохон шүүмж хүртэж, саадгүй даван туулсан туршлагатай.

Тэд 1990-ээд оны сүүлчээр хүнс хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлэхийн тулд 700 сая ам.доллар “салхинд хийсгэсэн” Webvan, видео тоглоом зэрэг дэлгүүрийн бараа бүтээгдэхүүний хүргэлтээр 300 сая ам.доллар алдсан Kozmo.com-ийн түүх Uber Eats дээр давтагдана гэж үзэж байв.


Хүргэлтийн үйлчилгээгээр ашиг олно гэдэг амаргүй. Хэдийгээр Uber Eats зоогийн газруудын тооцооны хуудаснаас чамгүй хувь хүртэж, 2-8 ам.долларын хүргэлтийн хөлс авдаг боловч тухайн хоол, хүнснийг очиж авах, хүргэж өгөх жолоочид төлбөр төлөхөөс гадна үйлчилгээгээ сурталчлах шаардлагатай. Uber-ийн шимтгэл зах зээлийн дунджаас бага, зоогийн газрууд хамгийн сайндаа л тооцооныхоо 30 хувийг хувааахааг зөвшөөрдөг. Uber хоол болон такси захиалсан хүнд зэрэг үйлчлэхгүйгээс хойш үйлчилгээгээ нэгтгэж ашиг олох боломж бага.

Гэсэн ч Uber-ийн хамгийн том өрсөлдөгч, нээлттэй хувьцаат Grubhub компани энэ төрлийн бизнесээс ашиг олж болохыг тодхон харуулдаг. Grubhub-ийн амжилтын нөлөөгөөр олон өрсөлдөгч төржээ. Uber зөвхөн АНУ-д л гэхэд баталгаат хөрөнгө оруулалттай старт-ап DoorDash, Postmates болон бизнесийн гигант “Amazon”-той өрсөлдөж байна.

Каланик Лос-Анжелес дахь Калифорнийн их сургуульд зурч байхдаа файл хадгалах, хуваалцах старт-ап хамтран байгуулж байсан Дрогед дайчилж, 2014 оны гуравдугаар сард Uber Everything-ийн захирлаар томилжээ. Дрогегийн үүрэг такси үйлчилгээтэй дүйцэхүйц өндөр ашигтай шинэ үйлчилгээ нэвтрүүлэх байв. Тэрбээр хүүхдийн живх, хөлс дарагч, цэцэг, химид өгсөн хувцас гээд нэрлэж болох бүхнийг хүргэхийг хичээжээ. Гэвч хоолноос бусад нь амжилтад хүрсэнгүй.

Тусгаар тогтнолын өдрөөр мөхөөлдөс, шарсан мах хүргэх зэрэг хэд хэдэн амжилтгүй оролдлого хийсний эцэст Uber анхны шийдвэрлэх алхамаа Uber Fresh-ээр эхлүүлэв. Энэ нь шөл, хавчуургатай талх зэргээр хөргөгчөө дүүргэсэн жолооч нар хотын дүүргүүдээр

Өлсгөлөн зах зээл (хувиар)
2016 онд АНУ-ын хоол хүргэлтийн зах зээлийн тав хүрэхгүй хувийг эзэлж байсан Uber Eats одоогоор 25 орчим хувийг эзэлж буй бөгөөд цаашид ч тэлэх төлөвтэй байна.



Wedbush Securities-ийн судалгаа

ТОГЛООМЫН ДҮРЭМ

Кен Кам

Өнгөрсөн наймдугаар сард Toyota компани Uber-г хөрөнгө оруулж үнэлгээг нь 76 тэрбум ам.долларт хүргэсэн бол Goldman Sachs, Morgan Stanley нар хувьцааг нь анхдагч зах зээлд гаргах санал тавьж, 120 тэрбум ам.доллараар үнэлэгдэнэ гэж үзжээ. Харин Morningstar-ийн зүгээс Uber Eats-ийг 20 тэрбум ам.доллараар үнэлсэнээр дээрх өсөлтийг хангана гэж тооцож байна. Uber Eats 36 улсын 200,000 зоогийн газарт үйлчилгээгээ нэвтрүүлбэл ийм үнэлгээнд хүрч магадгүй ч одоогоор 95,000 зоогийн газар, 16.4 сая үйлчлүүлэгчтэй Grubhub-ийн үнэлгээ 7.3 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна. Хоол хүргэлтийн үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьцаа сонирхож байвал Uber-ийн IPO-ийн хэт хөөрлөөс болгоомжилж, Grubhub-ийг сонгоорой. Кен Кам, Marketocracy компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал



эргэлдэж, захиалга өгсөн тохиолдолд хэдхэн минутанд хүргэх үйлчилгээ юм. Uber Eats-ийн хамт олон 2014 оны наймдугаар сард Лос-Анжелес хотод нээлтээ хийсэн өдрөө цаг хагасын дотор олон зуун хоол борлуулжээ. Энэ нь өдөрт найман ширхэг хөлс дарагчны захиалга авдаг байсантай харьцуулшгүй амжилт юм.

Тэд зах зээлээ оновчтой тодорхойлсон боловч бүтээгдэхүүнээ буруу сонгосон байв. Аппликэйшн дээр сонголт хийв үү, үгүй юу таван минутын дотор буррито барьсан жолооч хаалга тогших нь гайхалтай ч хэрэв захиалагч өөрийн хүссэн хоолоо захиалах боломж гарвал 30 минут ч хүлээж чадахыг анзаарчээ. Тиймээс тэд Uber Eats-ийг Aoga төсөл нэрийн дор чимээгүйхэн хөгжүүлсээр үйл ажиллагаагаа 2015 онд Торонто хотоос албан ёсоор эхлүүлжээ. Торонто хот Нью-Йорктой харьцуулбал өрсөлдөөн багатай ба улмаар Майами, Хьюстон болон Такома, Вашингтон зэрэг хотод тэлсэн аж. 2017 оны байдлаар Майами, Атлантад чамгүй ашигтай ажилласан нь тухайн бизнест ирээдүй байгааг илтгэж байв.

Харамсалтай нь, Uber Eats-ийн үйл ажиллагаа жигдрэв үү, үгүй юу ажлын байрны бэлгийн дарамт, хүйсээр ялгагарлан гадуурхсан, бизнесийн ёсыг зөрчсөн зэрэг шалтгаанаар Uber-ийн удирдлагын баг таран унав. Эцэст нь Каланик ажлаасаа чөлөөлөгдөж, жолоочгүй автомашин зэрэг салбар хариуцах удирдлагагүй хоцорлоо. Гэвч энэ бүхэн Дроге болон 2000 ажилтантай түүний багт сүйдтэй хохирол учруулсангүй.

Uber-ийн удирдлагуудын олж мэдсэн хамгийн олзуурхуштай мэдээ нь Eats-ийн үйлчлүүлэгчдийн дунд такси үйлчилгээ ашигладаггүй хүмүүс их байв. Өнгөрсөн жилийн судалгаагаар Eats-ээр үйлчлүүлдэг арван хүн тутмын дөрөв нь Uber-г анх удаа нэгдсэн байлаа. Өөрөөр хэлбэл, компани эдгээр шинэ үйлчлүүлэгчдийг такси үйлчилгээндээ харуулах боломжтой юм.

“Өнгөрсөн хугацаанд Uber-ийн нэвтрүүлсэн жолоочгүй автомашин, бараа бүтээгдэхүүний хүргэлт, ачаа тээвэр, дугуйн түрээс гээд бүхий л үйлчилгээнээс хамгийн амжилттай хэрэгжиж, удирдлагын анхааралд өртсөн нь Eats хэмээн хүргэлт үйлчилгээний өрсөлдөгч Eat24 компанийн гүйцэтгэх захирал асан Майк Гаффари үзэж байна.

Eats АНУ-ын зах зээлд эзлэх хувь хэмжээгээрээ Grubhub-тай тул дөхөж буй. Grubhub 2016 онд нийт зах зээлийн тэн хагасыг эзэлж байсан талаар Wedbush-ийн шинжээч Игал Аруньян ярьж байна. Харин 2018 онд энэ үзүүлэлт 34 хувь болон буурч, харин гурван хувь байсан Eats-ийн эзлэх хэмжээ 24 хувь хүртэл нэмэгджээ.

Өлсөхөөрөө хамгийн түрүүнд гар утсаа шүүрэн авдаг шинэ үеийнхэн Eats-ийн амжилтад жинтэй хувь нэмэр оруулдаг боловч өрсөлдөгчдийнх нь бизнесийг ч мөн адил дэмжиж буй. 2018 онд DoorDash нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авснаар зах зээлийн үнэлгээгээ гурав дахин өсгөж дөрвөн тэрбум ам.долларт хүргэсэн юм. Тэрчлэн Postmates 2018 оны сүүлчийн зургаан сард 400 сая ам.доллар татаж, 1.9 тэрбум ам.долларын үнэлгээнд хүрчээ. Эдгээр хоёр компани зөвхөн хоол хүргэлтийн үйлчилгээнд төвлөрдөг.

Uber Eats улам тэлэхийн тулд илүү олон харилцагч, зоогийн газрыг өөртөө нэгтгэх шаардлагатай. Дроге McDonald's, Starbucks-тай хамтарвал үйлчлүүлэгч Uber Eats аппликэйшнийг бусад өрсөлдөгчийнхөөс нь урьтаж нээнэ гэж үзэж байна. Тэрчлэн Uber Grubhub-ийн үндсэн бизнес загварыг хуулбарлаж, зарим зоогийн газрыг өөрсдөөр нь хүргэлт хийлгэж, хариуд нь тооцооны хуудаснаас ахуу хувь хүртэж буй.

Бизнесийн амжилт зоогийн газрын эзэдтэй хэрхэн харьцахаас л шалтгаална. Тодруулбал, Чикагогийн Si-Pie Pizzeria-ийн Саймон Михайл хоол хүргэлтийн олон компанитай хамтардаг боловч зөвхөн Uber Eats л түүнд зоогийн газартаа цахим үйлчилгээ нэмэхийг зөвлөсөн гэв. Учир нь тухайн дүүрэгт шарсан тахианы хайлт хамгийн их байгааг Uber Eats анзаарчээ. Өдгөө тэрбээр Uber Eats-ээр дамжуулж долоо хоногт 70 килограмм тахиа борлуулж байна. “Ашиг хуваалцах хувь хэмжээ нь харьцангуй өндөр ч үр өгөөжөө өгдөг” хэмээн тэдний тухай Михайл ярьсан юм. **Forbes**

[ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Брөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО
Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ
Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ
Улс төр, нийгэм, эрдэнэ сувалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энжжаргал
Утас: 99901621
Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574
Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
ЗАР СУРТАЛЧИЛГАА
Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn
ubinfo.mn
Дуугаарын удирдагч
Л.Сугармаа



Нийтлэлчийн булан

**Боловсон жорлонгүй
90 жил “хөгжсөн”
сүм тэрбумаар нь
сүм барьж буйг
ойлгодоггүй ээ**

◀1

Таван жилийн өмнө Монгол Улсын хэмжээнд 118 сүм түүхт тэгш ойгоо тэмдэглэсэн. Тухайн үед хандиваар цугласан мөнгөн дүн дунджаар 200-300 сая төгрөгт хэлбэлздэг байж. 2014 оны мэдээллээр Дорнод аймгийн Магад, Баян-Уул, Булган, Халхгол гэх дөрвөн сүм 90 жилээ тэмдэглэж, хандиваар 260-320 сая төгрөг цуглуулж зарцуулснаа аймгийн Засаг даргадаа тайлагнажээ. Дараа жил нь бас дөрвөн сүм тэгш ойгоо тэмдэглэн мөн тэрбум гаруй төгрөг цуглуулж байсан бол энэ жилээс ганцхан сумын хандив нэг тэрбум төгрөгөөс давах болов. Өнгөрсөн долоо хоногт телевизээр зүүн аймгийн нэгэн сумын засаг ноён “Манай сумын 90 жилийн ой өнөө жил тохиож байгаа. Хандиваар нэг тэрбум орчим төгрөг цуглуулж үүнийгээ 950 сая төгрөгөөр буддын сүм байгуулж түүхт ойдоо бэлэг барьж байна” хэмээн хөөрцөглов. Сумын ойг тохиолдуулан хандив цуглуулж, нутаг орныхоо өнгө зүсийг нэмдэг уламжлал эртнээс улбаатай ч сүм барьж сумаа хөгжүүлнэ хэмээн хэнээрхсэн нь арай л хэтэрсэн хэрэг.

Өмнөх сумд шиг цугласан хандиваар будаг шохойны ажил хийгээд сумын төвийнхөө өнгө зүсийг сайжруулсан бол гэх бодол ч энэ зуур зурсхийнэ. Хандиваар цугласан 950 сая төгрөгөөр сургууль, соёлын төвөө тордох, эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээгээ сайжруулсан бол зочдоо нүүр бардам угтах байсан биш үү. Ядаж алдартнуудаа мөнхөлсөн хөшөө баримал суурилуулсан бол сүм орноороо бахархах сэтгэгдэл төрүүлэх байв. Гэтэл сүм барьж сумаа хөгжүүлсэн гээд хэв нэг яриад зогсох нь байна. Сүм барьснаар тухайн сумын хөгжил хэрхэн шат ахидгийг ойлгох үндэслэл олддоггүй. Мухар сүсэг, сохор итгэл хоёр л дээшилж байгаа дүр зураг буугаад болдоггүй ээ.

Судалж үзвэл сүүлийн үед сумын төвд хандив, тусламжаар сүм барьдаг “моод” дэлгэрээд байгаа аж. Нэг хэсэг аймаг, сум бүр зочин угтах, үдэх хаалга барьж уралдсан бол тэр нь морь малын хөшөөгөөр үргэлжлээд өдгөө сүм барих “моод”-оор үргэлжилж байна. Айлаас дутахгүй гэсэн хүсэл, жалга довны үзэл хэтрээд эхлэхээр тэнгэглэл болж хувирдгийг танай манайдаа тулсан талцал хэрүүлээс олон жишээ баримтаар дурдаж болно. Гэхдээ сүм барьж “барьцана” гэдэг арай хэгийдсэн тэнгэглэл шиг санагдахгүй байна гэж үү.



С.Батсайхан / ЗГМ

Сүм барьж сум хөгжүүлэх ТЭНЭГЛЭЛД АВТЖЭЭ

● **Үндэсний статистикийн хорооны судалгаагаар өнөөдөр 80 гаруй сүм буддын сүмтэй болжээ.**

● **Зүүн аймгийн нэгэн сумын засаг дарга “950 саяар хийд барьж түүхт ойдоо бэлэг барьж байгаа” хэмээн хэнээрхэж сууна.**

● **Мөнгө олдоггүй энэ олон сүм хийдийг арчлах тордох ажил эргээд сум, орон нутгийн төсөвт хүндрэл учруулдаг.**

Үндэсний статистикийн хорооны судалгаагаар өнөөдөр 80 гаруй сүм буддын сүмтэй болжээ. Ислам, христийн сүмийг нэмбэл 200 хол давсан тоо гарах нь байна. Эдгээрээс Сүхбаатар аймагт хамгийн олон буюу 11 буддын сүм шинээр баригджээ. Өнгөрсөн жил гэхэд л Баруун-Уртал нэг тэрбум, Уулбаян суманд 560 сая төгрөгөөр хэмжигдэх хоёр ч хийд баригдсан. Энэ мэтчлэн аймаг, сүм бүрт шинээр баригдсан сүм хийдийн дүн мэдээг гаргаж болно.

Энэ олон сүм сум орны хөгжилд нэмэр болдог бол ойлгож үзэхсэн. Гэтэл сүм хийд татвараас чөлөөлөгддөг болохоор сумын төсөвт нэг ч төгрөгийн орлого оруулдаггүй. Дотоод, гадаадын аялал жуулчлалаас мөнгө “саадаг” сүм Хархорин, Хамарын хийд гэгээд дуусчихаж байна. Сүмээр мөнгө олоод сумынхаа хөгжлийг дэмжсэн тохиолдол ч дээрх хоёроос хэтрэхгүй. Ийм нөхцөлд сумын төвд сүм барих нь хэгийдсэн хэнээрхэл гэхээс өөр гаргалгаа алга. Харин Өвөрмонголд түүхэн үйл явдлыг зохиомжилж, үзмэр бэлтгээд түүнээ мөнгө олох хэрэгсэл болгон ашиглаж байна. Сяньби үндэстэн, Монголын эх үүсэл, Чингисийн сүм, Монгол хан хот, Майдар зуу зэрэг 50 гаруй аялал жуулчлалын бүсийг бий болгож нутаг орноо хөгжүүлж байна. Манайд эсрэгээрээ нутгийнхаа иргэдэд л алдаг оног үйлчлэх хязгаарлагдмал газар бий болгоод түүнийгээ 90 жилийн ойн бэлэг болгон “попорч” байгааг ойлгодоггүй ээ.

Ная, ерэн жил болсон сумд түүхэн хөгжлийн ойгоо тэмдэглэх, сүм барьж чамирхах нь нэг талдаа гадаадынхны инээд,

шүүмжлэлийг байнга дагуулдаг болжээ. Өнгөрсөн жил түүхэн хөгжилт тэгш ойн баяраа тэмдэглэж буй сумын наадамд очсон гаднын жуулчин ичих багадаж, уурлах ихдэхээр зүйлийг МҮОНРТ-ээр ярьж байсныг

санаж л байгаа.

“90 жил хөгжихөөд сумын хэмжээнд стандартад нийцсэн ганц ч боловсон жорлонгүй байгаа нь гайхалтай” хэмээсэн тэр хүний үг доромжлол мэт санагдавч та биднийг шүүм-

жилсэн том сургаал байжээ. Эндээс л тэрбум төгрөгөөр сүм барьж “өвчигнөж” байхаар гадна дотнын зочдыг тохитой амрааж, тухтай наадахад мөнгөө зардаг болчихвол гэсэн бодол гол зураад байгаа юм. [ЗГМ]

ТӨРИЙН БАНК
ЭРСЭДЭГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

**ТӨРИЙН БАНК ТОП-5 БАНКНЫ
НЭГЭЭР 6 ДАХЬ УДААГАА
ШАЛГАРЛАА**

Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТанхимаас хамтран жил бүр Монгол Улсынхаа нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй шилдэг 100 аж ахуйн нэгжийг шалгаруулдаг уламжлалтай бөгөөд 2018 онд амжилт бүтээлээрээ манлайлсан ТОП-100 аж ахуйн нэгжид хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт боллоо.

Тус арга хэмжээнд Төрийн банк ТОП-100 аж ахуйн нэгжээс 14 дүгээр байрт, банкны салбарын шилдэг 5 банкны нэгээр 6 дахь удаагаа шалгарлаа.

2018 онд Төрийн банк Монгол Улсад анх удаа repo хэлцэл хийн валютын эх үүсвэрийг татан төвлөрүүлж, ахуйн хэрэглээний зээлийн хүүгээ бууруулж харилцагчиддаа бага хүүтэй зээл олгож, банкны нөөц дата төвөө үндсэн дата төвөөс 200 километрын зайд байршуулан харилцагчдын мэдээллийн сангаа гал, усны эрсдэлээс хамгаалах нөхцөлийг арилжааны банкуудаас хамгийн түрүүн биелүүлсэн.

Мөн Төрийн банкны хувьд 2018 онд нийт активаа 27.9 хувиар өсгөн 2 их наяд 989.9 тэрбум, татан төвлөрүүлсэн хөрөнгөө 30.5 хувиар өсгөн 2 их наяд 716.8 тэрбум төгрөгт хүргэж, нийт зээлийн багцаа 28.3 хувиар өсгөсөн амжилтаараа Монгол Улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулж эдийн засаг, бизнес, санхүүгийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн шилдгүүдийг шалгаруулдаг “Bloomberg TV Mongolia Awards 2018”-аас “Шилдэг Өсөлт” шагналыг Төрийн банкны Гүйцэтгэх захирал Г.Дөлгөөн гардан авсан.

Түүнчлэн, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган 2018 оны санхүүгийн тайлангаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дөрвөн том аудитын байгууллагын нэг болох “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-аар хийлгүүлж, Олон улсын зэрэглэл тогтоогч “Moody’s” агентлагаас банкны зээлжих зэрэглэлийг шинэчлэн хэтийн төлөвийг “Тогтвортой” гэж дүгнэсэн.

Төрийн банкинд итгэл хүлээлгэн хамтран ажиллаж буй нийт харилцагч Та бүхэндээ талархал илэрхийлэн, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

1800-1881
www.statebank.mn

“МИАТ” ТӨХК ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖЭЭР ШАЛГАРЛАА



Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран жил бүр улс орны нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй аж ахуйн нэгжийг шалгаруулдаг уламжлалын дагуу 2018 оны ТОП-100 аж ахуйн нэгжийг тодруулж алдаршууллаа.

Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийг эдийн засгийн хөгжлийн гол хөшүүрэг болж, улсын татварын орлогыг бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан амжилтаар нь 2018 оны ТОП-100 аж ахуйн нэгжээр тодруулан өргөмжлөл гардуулжээ.

ТОП-100 аж ахуйн нэгжийг тодруулахдаа Сангийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн

ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагын статистик мэдээлэлд үндэслэн аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн орлого, улсын төсөвт оруулсан татвар, нийгмийн даатгал төлсөн ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ гэсэн үндсэн 5 үзүүлэлтийг харгалзан тодруулдаг бөгөөд “МИАТ” компани сүүлийн дөрвөн жил дараалан ийнхүү ТОП-100 аж ахуйн нэгжээр шалгарч байна. “МИАТ” компани 2018 онд олон улсын ес, орон нутгийн нэг чиглэлд нийт 2,294 удаагийн аяллаар 712,545 зорчигч тээвэрлэсэн нь түүхэндээ хамгийн өндөр үзүүлэлт юм.

Технологи

УЯН
ДЭЛГЭЦТЭЙ
LOUIS
VUITTON
ЦҮНХ

О. Мишээл

Францын люкс зэрэглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Louis Vuitton компани Нью-Йорк хотноо зохиогдсон Cruise 2020 шоу арга хэмжээний үеэр өвөрмөц шинэ загвар-нимгэн уян дэлгэц бүхий эмэгтэй хүний цүнх сонирхуулаа. Тус компанийн шинэ загварын энэ цүнх нь орчин үеийн тоон технологийг хамгийн энгийн хэрэглээтэй хэрхэн “нэгтгэж” болохыг харуулсан бүтээл болов.

Цүнхний хажуу талд органик гэрлийн диодонд суурилсан AMOLED технологитой нимгэн уян дэлгэц оруулж өгчээ. Дэлгэцийн дүрсний нарийвчлал 1920 x 1440 пиксель. Шоуны үеэр тус компани нимгэн дэлгэцтэй хоёр төрлийн цүнх сонирхуулсны нэг нь нэг бүтэн, нөгөө нь хоёр тусдаа дэлгэцтэй байв. Дэлгэцнээ гэрэл зураг, видео контент гаргаж болох ба бүтээгдэхүүний техник үзүүлэлттэй холбоотой илүү

нарийвчилсан мэдээлэл хараахан байхгүй байна. Одоогоор худалдаанд хараахан гарч амжаагүй уг сонирхолтой загварын үнэ хэдэн мянган ам.доллараар хэмжигдэнэ хэмээн сонирхогчид таамаглаж байна. [ЭГМ]

Toyota, Panasonic
ухаалаг гэрийн технологид
хамтарч ажиллана

Ирээдүйн хот байгуулалт, ухаалаг орон сууцанд ашиглах “холболттой” технологи хөгжүүлэх хамтарсан компани байгуулахаар Японы Toyota Motor Corp болон Panasonic Corp тохиролцлоо.

Энэхүү тохиролцоо нь дэлхийн тэргүүлэх авто үйлдвэрлэгч, автомашины аккумулятор, зай хураагуурын шилдэг үйлдвэрлэгчдийн хоёр дахь

томоохон хамтын ажиллагаа болж байна. Тус компаниуд цахилгаан тээврийн хэрэгсэлд зориулсан зай хураагуурын үйлдвэр хамтарч байгуулахаар энэ оны нэгдүгээр сард мөн тохиролцсон билээ.

Ирэх жилээс ажиллаж эхлэх тус хамтарсан компани нь орчин үеийн ухаалаг орон гэрт зориулсан шинэ төрлийн үйлчилгээ хөгжүүлнэ. [ЭГМ]

Виртуал
сургалтын
төхөөрөмжийн
эрэлт ихэсчээ

Компанийн ажилтнуудыг даллагажуулах виртуал сургалтын төхөөрөмжийн дэлхийн зах зээл жилд дунджаар 13 хувь өсөж, 2025 он гэхэд 20 тэрбум ам.доллар давах төлөвтэйг Global Market Insights компанийн шинэ судалгаа харуулаа.

Үйлдвэрлэлд автоматжуулалт, робот технологи эрчимтэй нэвтэрч байгаа нь сургалтын төхөөрөмжийн зах зээл өсөх шалтгаан болж байгааг судалгаанд тайлбарлажээ. Мөн төрийн зохицуулалт, үйлдвэрлэлийн аюулгүй байдалд тавьдаг шаардлага чангарч байгаа нь ч ажилтан, ажилчдыг даллагажуулах симулятор төхөөрөмжийн эрэлт өсөх бас нэг нөхцөл боллоо.


Шинэ судалгаанаас үзвэл барилга угсралт, уул уурхайн салбарт мэргэжилтэй ажиллах хүчин дутагдах хандлагатай байна. Ур чадвартай мэргэшсэн ажилтан болон ажилтан шинээр хөслөх зардал өндөр байгаагаас компаниуд ажиллах хүчээ сургаж, даллагажуулахад анхаарах нь ихэссээр байна.

VR (Virtual Reality) буюу хиймэл бодит байдлын техно-



логи улам сайжирсны үр дүнд уламжлалт суурин дэлгэцтэй төхөөрөмжийг (Head Mounted Display) буюу толгойд бэхэлдэг сургалтын модуль-дэлгэцээр орлуулах хандлагатай болов. HMD нь ялангуяа үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, операторуудын осол гэмтлийг

бууруулахад чиглэсэн сургалтын зориулалттай даллагажуулагч техник хэрэгсэлд эрчимтэй нэвтэрч байна. Ажлын аюулгүй байдлыг сайжруулахад чухал үүрэгтэй, зайн сургалт дэмждэг даллагажуулагч төхөөрөмж нь компаниудад зардал хэмнэх давхар ач холбогдолтой юм. [ЭГМ]

Террористуудыг устгах зориулалттай
“нинжа-бөмбөг” бүтээжээ

Ойр зэргэлдээ байгаа энгийн иргэдэд хөнөөл учруулахгүйгээр алан хядагчдыг устгах чадвартай Пентагоны нууц зэвсгийн тухай Wall Street Journal (WSJ) мэдээллээ. Тус сонинд гарсан мэдээллээс үзвэл АНУ нууц зэвсгийнхээ “ид шид”-ийг дэлхийн таван улсад хэдийн амжилттай туршин шалгажээ.

“Нинжа-бөмбөг”, “нисдэг Ginsu” (Ginsu-хутганы нэр) хэмээн томъёолсон нэр бүхий RX9X пуужин нь Тагнуулын Төв Газар, Пентагоны хараалсан цохилт өгөхөд ашигладаг Hellfire пуужингийн сайжруулсан тусгай хувилбар юм. Пуужингийн

байлдааны хошуунд тэсрэх бодисын оронд барилгын дээвэр, автомашины кузов цөм цохиж нэвтлэн байг устгах чадвартай пуужин байг ономогц гадагш дэлгэгддэг зургаан ширхэг хурц ирийг хошуунд суурилуулсан нь цохилтын хөнөөгч хүчийг ихэсгэх зорилготой.

Энгийн иргэдийг амьд бай болгон ашигладаг террористуудын эсрэг байлдааны ажиллагаанд энгийн иргэд үрэгдэх явдлыг бууруулах зорилгоор Пентагон “нинжа-бөмбөг” бүтээх ажлаа 2011 оноос эхлүүлжээ. Алан хядагчдыг устгах

ажиллагаанд энгийн пуужин ашиглах нь террористуудын зэргэцээ гэм буруугүй энгийн номхон иргэдийг хөнөөхөд хүргэдэг аж.

Hellfire гэх мэт пуужин нь тээврийн хэрэгсэл болон алан хядагчдын үлэмж хэмжээний амьд хүч төвлөрсөн газарт цохилт өгөхөд, харин R9X пуужин тодорхой террористыг онилж устгахад илүү тохирох юм байна.

R9X пуужинг Ливи, Ирак, Сири, Сомали, Йеменд явуулсан байлдааны ажиллагаанд ашигласныг Пентагоны албаны хүн баталж байна. [ЭГМ]

ЭМГЭНЭЛ



“МИАТ” ТӨХК-ийн
ахмад нисгэх механикч
Заяагийн ВАРИЙНА
(1932- 2019 он)

“МИАТ” ХК-ийн анхдагчдийн нэг ахмад нисгэх механикч З.Варийна 1932 онд Говь-алтай аймгийн Шарга сумын уугуул, малчны гэр бүлээс гаралтай эгэл ардын нэгэн билээ. Тэрбээр 1956 оноос Ардын армийн нисэх 5-р хороонд онгоцны техникчээр ажил хөдөлмөрийн гараагаа эхлэн 1959-1987 онд

Өвөрхангай аймгийн нисэх буудлын ахлах техникч, буудлын дарга, АХГ-ын Онгоцны Нэгдсэн Засварын Газарт техникч, цехийн дарга, Нисэх эскадрильд Ил-14, Ан-24,26,30 онгоцны нисгэх механикчаар ажилласан ахмад нисгэх механикчдийн нэг юм.

“МИАТ” ТӨХК үүсэн байгуулагдсан түүхэн он буюу 1956 онд Цэргийн Ерөнхий Сургуулийн нисэхийн анги төгссөн онгоцны техникч мэргэжилтэй, дэслэгч цолтой цэл залуухан З.Варийна шинээр байгуулагдсан “МИАТ” хэмээх их айлд ирж, тулгын чулууг нь тавилцсан анхдагчдын нэг болох агуу хувь заяатай байжээ. Иймээс З.Варийна “МИАТ” компанийг үүсгэн байгуулагчдын нэг гэж албан ёсоор нэрлэгдэх түүхэн гавъяатай хүмүүсийн нэг юм.

З.Варийнагийн хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндөр үнэлж Ардын хувьсгалын 40, 50, 60, 70, 80, 90 жилийн ойн медаль, Зэвсэгт хүчний 50, 60 жилийн ойн медаль Байлдааны медаль, Алтан гадас одон, Цэргийн гавьяаны одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж Монгол Улсын нисэхийн гавьяат техникч цол хүртээжээ. Эрхэм нөхөр З.Варийнагийн нөхөрсөг, тусархаг, ажилч хичээнгүй зан чанар бидний зүрх сэтгэлд үүрд мөнх дурсагдах болно.

“МИАТ” ТӨХК-ийн удирдлага, хамт олон,
Ахмадын хороо.

ZGM DAILY

MPs agree to discuss the draft law on control of licenses

The permits are to be classified into two categories.

Xanadu Mines: 3618.5 meters drill has been done in Q1

The share price of Xanadu Mines rose 1.16 percent to CAD 0.09.

Lhagvajav Baatarjav: Political issue of Mongolia influences the economy

There is a basic need to prepare specialists who have economic knowledge.

Top 20 index up 0.29 percent, to 20,246.63 points

Market cap stands at MNT 2.35 trillion.

ZGM: HIGHLIGHTS


POLITICS

Deputy Chairman of the Democratic Party Batkhuu Gavaa passes away in the Government House on May 17, 2019. The case is being investigated under the legal control of the Prosecutor's Office at the Investigation Department of the National Police.

ECONOMY

Erdenes Methan LLC and Jade Methan LLC of Australia sign investment agreement to establish methane reserves of coal seams of coal at Tavan Tolgoi residual deposits.

Top 20 index up 0.29 percent, to 20,246.63 points. MSE A index decreases 0.2 percent to 9,346.15 points. MSE B index increases 0.32 percent, to 7,840.7 points. Market cap stands at MNT 2.35 trillion.



SOCIETY

Mongolian Minister of Road and Transportation Development Byambasuren Enkh-Amgalan issues a decree on restricting travel on highways linking the capital to several provinces due to strong winds and snowstorms.

Mongolian MC Mrs.M releases the video for "Tasty," which is produced by Silverstrike and mixed by Pro Era's Nasteher, and the first-ever song in the English language.

The Ulaanbaatar Marathon, International Tournament takes place for the sixth year on May 18. More than 30,000 people have participated.

Parliament discusses online license grants

The bill will allow licenses to be granted via one-stop centers or online

Aminaa.U
ZGM

At the parliamentary session on Friday, MPs discussed the bill on transparency and control of licenses. The draft regulated the granting and extensions of licenses via one-stop service centers or online.

In addition, the permits are classified into two categories. Under the law, licenses shall be effective for less than 5 years and the minimum period will be less than 3 years. The rights and obligations of the license, registration, information of the consent, the electronic database, and activities to prohibit the operation are included in the bill. It also provides a clear description of the type and the permits granted by a single and multiple-authority consents.



Batsikhan.S / ZGM©

The project conceives submitting the person authorized to issue the permit, increasing responsibility and oversight,

setting the grounds and procedures for transferring the rights to others, simplifying licensing procedures and establishing a

unified database. The draft law has been developed to establish a legal environment for the Licensing Supervisory Board to provide

authorized methodological guidance, to evaluate the effectiveness of the law, to make a conclusion and to reform the law. [ZGM]

MINING

Xanadu Mines: 3618.5 meters drill has been done in Q1

Xanadu Mines, listed on the Australian Stock Exchange (ASE), introduced the exploration process of the Kharmagtai deposit. In the first quarter of this year, diamond drilling was made in 3618.5 meters.

The company emphasized that the positive results of the reserves were confirmed. Also, they are planning to do additional drilling and research. By the end of the first quarter, the Xanadu Mines cash

balance was AUD 3.1 million. The post-tax losses also fell by two-fold from the previous year to AUD 0.9.

In addition to this information, the share price of Xanadu Mines rose 1.16 percent to CAD 0.09. The Kharmagtai copper-gold Project is located within the South Gobi porphyry copper province of Mongolia, approximately 440km south-southwest of Ulaanbaatar and 120km north of Rio Tinto's Oyu Tolgoi copper-gold mine. [ZGM]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт" /Баянгол дүүрэг 18 дугаар хороо/-ын ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/075

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос "Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт" /Баянгол дүүрэг 18 дугаар хороо/-ын ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо: Сүүлийн 2 жилийн (2017, 2018 он) борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Зураг төсөв боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд хуулбарлан ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш.
3Т-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш.

1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв болон түүнээс дээш эсвэл 3Т-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв болон түүнээс дээш.

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт болон түүнээс дээш, эсвэл БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил болон түүнээс дээш.

Тендерийн хамт 1,000,000 /нэг сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

ZGM: INTERVIEW

Lhagvajav Baatarjav: Political issue of Mongolia influences the economy

Aminaa.U
ZGM

Bloomberg TV Mongolia recently organized the New Economic Forum. We had a chance to interview one of the moderators of the economic forum Lhagvajav Baatarjav, former president of the Mongolian National Chamber of Commerce and Industry (MNCCI). He strongly believes that the participation of professional associations, researchers and scholars is important to decrease the over-involvement of the government in business and economy.

-What do you think was the unique feature of the New Economic Forum compared to the previous forums?

-The economic forum in 2009 was different. We used to protest on the streets demanding to discuss the facing issues in 2006-2009. Afterward, we talked about the economic problems at the state palace. However, it has lost its meaning and turned into an advertisement for politicians. The method has been changing over time.

The New Economic Forum was so efficient and focused on the main point. It also accomplished the pur-



Gerechuluun.J / ZGM©

pose, which was to let the economic and financial field professionals speak. Scholars, researchers, analysts, banking sector, and business representatives were gathered at the same time.

-What will be the outcome in your opinion?

-There is growth in the economy but the players who do not have enough knowledge about the economy tend to steal the business opportunity by using government authority. Professionals need to work together in order to prevent it. The forum is the beginning of it.

-Economists discussed if Mon-

golia is ready for the next crisis. How would you describe the upcoming potential crisis?

-We have been going through the crisis for four years in 2012-2016. Almost all companies were in such a difficult situation barely running in 2016. The economy is just beginning to rise again. We are talking about the external and internal trade-related crisis. However, the problem for our country is that political issues affect the economy as well.

-Is the gathering of experts the first step in diminishing political intervention in the economy?

-Of course, it is. Economists will think far better than those populists. In addition, there is a basic need to prepare specialists who have economic knowledge in every field. For example, a lawyer cannot judge or solve the cases of businessmen and politicians fair enough without studying economics.

-What policy should we adopt for investors to make an easy choice?

-The main factors that hesitate the foreign investors are the spending of the fund without a plan and absence of the right method. Businesses are becoming too dependent on politics. We need a proper environment to invest in. [ZGM]

Өдрийн өнгө



ЗУРХАЙ

Билгийн тооллын 17
Зуны тэргүүн шарагчин луу сарын таван шар мэнгэтэй улаагчин могой өдөр
Үс засуулбал: Өнгө зүс доройтно
Наран ургах, шингэх: 05.09-20.29
Барилдлага: Идэр
Шүтэн барилдлага: Нэр өнгө
Суудал: Шороо

Аргын тооллын тав дугаар сарын 20. Сумъяа гараг. Билгийн тооллын 17. Эрхтэний тэнгэрт одтой, улаагчин могой өдөр.
Өдрийн наран 05.09 цагт мандан, 20.29 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр байрагдуулах, буг дарах, гаурын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой.



“The HU-GEREG live Performance” концерт
Хаана: White Rock Center
Хэзээ: 2019.05.23-24 ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮99,999



“Сэтгэлийн километр” концерт
Хаана: Embassy restaurant-Бишрэлт
Плаза зочид буудал
Хэзээ: 2019.05.24-ний 18.30 цагт
Тасалбарын үнэ: ₮ 30-50 мянга



Ж.Верди “Аида” дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.25-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



“Диваажинд хүрэх зам” дүрслэлийн шинэ технологи

Найруулагч Д.Ганцогтын бүтээл “Диваажинд хүрэх зам” уран сайхны кино энэ сарын 17-нд Зайсан хил цогцолборын кино театрт нээлтээ хийлээ. Mesmerism продакшн, BRB ХХК, ХМФ-Хуур хөгжмийн наадам, Монгол HD телевиз хамтран тус киног бүтээжээ. Рой Кларкийн “Луйварчид” зохиолоос сэдэвлэн

бүтээсэн уг киноны зургийг дэлхийн номер нэг ARRI камераар хийсэн нь илүү мэргэжлийн, чанарын өндөр түвшинд хүргэсэн гэдгийг найруулагч онцлов. Кинонд хүсэл зорилгынхоо төлөө тэмүүлж буй хоёр найзын амьдралын үнэ цэн, хэнд ч дийлдэшгүй хүсэл мөрөөдөл, үнэнч нөхөрлөлийг харуулжээ.

Киноны зургийг зургаан сарын хугацаанд, 80-100 хүнийг оролцуулан авсан байна. Гол дүрд залуу жүжигчин С.Идэрмаа, Э.Мөнх-Эрдэнэ, Д.Ганцогт, дүүрүүдэд МУАЖ С.Сарантуяа, МУГЖ Ц.Төмөрхуяг, МУСТА О.Гэрэлсүх, Б.Батзаяа, Б.Навчаа, Б.Ангараг, У.Содхүү нар тогложээ. [31M]



Ф.Херольд “Дэггүй Лиз” балет
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.26-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



Ц.Балдорж “Хайрын виз” уянгын драм
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.05.28-30-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



“Маамуугийн төрсөн өдөр”
Хаана: White Rock Center
Хэзээ: 2019.05.31-ний 11.00, 14.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 15 мянга

ЗГМ: СУДОКУ

	5	8	1			
6		7				4
8		4		7	5	6
	9		3		8	7
			7	4	9	2
						1
2	8	6		4	9	
			2	5	3	
		7		1	6	

(Өмнөх дугаарын хариу)

6	2	3	8	1	5	7	4	9
7	4	8	2	9	9	5	1	6
9	1	5	7	6	4	2	3	8
8	9	4	1	2	6	3	5	7
2	6	7	9	5	3	4	8	1
5	3	1	4	7	8	9	6	2
1	8	2	3	4	7	6	9	5
3	5	9	6	8	2	1	7	4
4	7	6	5	9	1	8	2	3

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5	6	7
8						
9		10			11	
		12		13		

БОСООГООР:
2. Хадны завсар зулзагаа хавчуулж орхиод анд явдаг хоёр

нутагтан
3. Баяр цэнгүүн
4. Улсын төсвийг бүрдүүлэх гол эх үүсвэр

ХӨНДЛӨНГӨӨР:
1. VIII/23-IX/22 хугацааны одны ордн нэр
4. Цастын орон
6.Нурууны 12 дахь үе
8. Манай орны баруун хягаарын их нуруу
9. Цагтаа манайхан хүртэл хэрэглэдэг асан оросуудын хурайлах хэллэг
10. Будда тарианы ерөнхий

нэр
11. Хавирга бүхий цагаан будаатай 2-р

хоол
12. Нэгэн зүйлийн матар
13. Дулаан, (... орох)

Өмнөх дугаарын хариу / 05.17

Т	У	Н	Г	А	Л	А	Г	Т	А	М	И	Р
Е	А	Л	Я	А	Ө	О						
Р	О	Я	Л	Т	И	Ө	В	Г	Ө	Н	Т	
Е	А	А	А	А	А	Г	В					
Ш	И	Э	Н	Х	М	Э	Н	Д	Р	Е		
К	А	Т	Ь	Х	С	И						
О	Р	Д	У	У	Д	Х	А	Р	У	У	Л	
В	А	У	Я	Н	У	Е						
А	М	Г	А	Л	А	Н	Б	А	А	Т	А	Р

ТОП 100

АЖ АХУЙ НЭГЖЭЭР ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ 27 БАЙГУУЛЛАГА ШАЛГАРЛАА.



ЭДИЙН ЗАСАГ

Сэтгүүлийн зохиолчид "үнэд орлоо"

Холливудын студиуд худалдан авдаг сэтгүүлийн материалын тоо сүүлийн арван жилд өсөх хэрээр үнэд оров. >10



Корнелийн их сургуулийн профессор өөрийн гэсэн криптовалюта гаргалаа

Avalanche протокол нь Bitcoin-хоос илүү уян хатан, хүчирхэг ажиллагаатай хэмээн Сирер тайлбарлав. >10

Шон Доннан

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп худалдааны дайныг шинэ түвшинд гаргаж, улам шийдвэрлэхэд төвөгтэй болголоо. Тэрбээр Хятадын технологийн аварга Huawei-г онилсон захирамж гаргасан бол Европ болон Японы машин үйлдвэрлэгчидтэй шийдвэр гаргажээ. Ингэснээр АНУ-ын үндэсний аюулгүй байдлыг хамгийн өргөн утгаар нь хэрэглэх үүд хаалгыг нээв. Трампын энэхүү алхам дэлхийн худалдааны журмын цоорхойг ашиглан өмнөх Засгийн газрууд хийхээс түдгэлзэж байсан зүйлийг хэрэгжүүлсэн явдал боллоо.

Тухайлбал импортын автомашин Америкийн үндэсний

болсныхоо дараа ийм үндэслэлээр ган ба хөнгөн цагааны импортод тариф ногдуулсан. Өнгөрсөн онд мөн заалтыг ашиглан импортын машины талаар мөрдөн байцаалт



ТОУОТА ТРАМПЫГ ЗЭМЛЭЖЭЭ

Честер Доусон

Японы авто үйлдвэрлэгч Toyota Motors компани АНУ-ын Ерөнхийлөгч "Импортын машин үндэсний аюулгүй байдалд заналхийлж байгаа" мэтээр ярьж байгаа нь худалдааны хэлэлцээний өмнө зөрчилтэй мессеж өглөө хэмээн шүүмжилсэн байна. Нэлээд хатуу үгтэй тус мэдэгдэлд "Трампын яриа манай хөрөнгө оруулалтад таагүй хандах сэтгэгдэл төрүүлж байна. Америк дахь манай ажилчдын хувь нэмрийг үнэлсэнгүй" хэмээн зэмлэжээ. Toyota АНУ-д 60 тэрбум ам.доллар зарцуулж, 10 үйлдвэр байгуулснаа мэдэгдэв. Тус компани ердөө хоёр сарын өмнө гурван тэрбумын ам.долларын хөрөнгө оруулалтыг АНУ-д нэмж хийхээ зарласан юм. Түүнчлэн Америкийн компаниуд Трампын тарифын улмаас автын салбарын 700 мянган ажлын байр эрсдэл орохыг анхаарууллаа.



АНУ-ЫН ХОРИГ HUAWEI-Д ОНЦ НӨЛӨӨЛӨХГҮЙ ГЭВ

Жим Силвер

Huawei-г үүсгэн байгуулагч хийгээд ерөнхий захирал Рен Жеңфей АНУ-ын хориг Хятадын компанид онц нөлөөлөхгүй хэмээн мэдэгдсэнийг Nikkei эш татан мэдээллээ. Тэрбээр Шеньжен дэх компанийн төв байранд Японы сэтгүүлчидтэй ярилцахдаа "Манай өсөлт жаахан саарах боловч энэ нь үл ялиг хэмжээтэй" хэмээн онцлов. АНУ-ын Ерөнхийлөгч болон Худалдааны яам тус компанийн эсрэг хийсэн арга хэмжээний дараа анх удаа ноён Рен мэдэгдэл хийсэн нь энэ юм. Түүний тооцоогоор орлогын өсөлт нь 20 орчим хувь буурах төлөвтэй аж. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Хятадын Huawei ба ZTE компанийн тоног төхөөрөмжийг аюулгүй байдлын шалтгаанаар Америкийн зах зээлд худалдахыг хориглосон захирамжид гарын үсэг зурсан юм.


Машины импортыг АНУ-ын үндэсний аюулгүй байдалтай холбов

аюулгүй байдалд заналхийлж буй мэтээр мэдэгдэж, импортыг танах арга зам эрэлхийлэв. Энэ нь олон улсын хууль зохицуулалтыг үндэсний аюулгүй байдал нэрийдлээр мушгин гуйвуулах оролдлого юм. Трампын захиргаа Европ, Японтой машин болон сэлбэгийн импортыг бууруулах талаар хэлэлцээгээ үргэлжлүүлэх хугацааг 180 хоногоор сунгахаар шийдвэрлэсэн.

АНУ-ын тагнуулын албаныхан Huawei-г Хятадын ардын чөлөөлөх армитай холбоотой гэх үндэслэлээр хориглохыг олон жилийн турш шаардаж ирсэн. Гэвч импортын машин үндэсний аюулгүй байдалд заналхийлнэ гэдэгтэй санал нийлэх хүн ховор. Машины талаар яригдаж байгаа зүйлийг шинжээчид хагас дамжуулагч гэх мэт нарийн салбартай холбон урьд нь хөндөж байсан билээ. Үүнийг машинд хэрэглэхийг хэн ч ул суурьтай зүйл гэж үзсэнгүй.

Huawei болон машины асуудлын цаана үндэсний аюулгүй байдал бол эдийн засгийн аюулгүй байдал хэмээх санаа агуулагдаж буй. Улмаар ноён Трамп Ерөнхийлөгч

АНУ-ын машин ба сэлбэгийн импортын хувь хэмжээ, улс, орноор



эхлүүлсэн юм. Машины тарифыг гадаад, дотоодын үйлдвэрлэгчдийн аль аль нь эсэргүүцэж байна. Хэрэв уг тариф хэрэгжвэл Европ, Японтой хийж буй худалдааны хэлэлцээг гацаах нь дамжиггүй.

Хоёр намын Конгрессын гишүүд Ерөнхийлөгч худалдааны протекционизмын талаар хууль тогтоогчдоос олгосон эрх хэмжээг хэтрүүлж байна хэмээн шүүмжилсэн. Ган импортологчид дээд шүүхэд хандаж, 1962 оны Худалдааны хуулийн 232-р зүйлийг Ерөнхийлөгч хэрхэн бижуулах санал хүргүүлжээ. Бусад бизнесийн бүлгүүд ч уг хүчин чармайлтад нэгдэж эхэллээ.


Дэлхийн худалдааны журамд дайны цаг үед улс орнуудад худалдааг хязгаарлах боломжийг тусгасан байдаг.

Энэ асуудал түүнчлэн ДХБ-д сөхөгдөж, АНУ ба бусад орнуудын хооронд маргаан үүсгэх төлөвтэй байна. Трампын засгийн эрхэнд гарахаас өмнө АНУ үндэсний аюулгүй байдлыг бусад орнууд олон улсын худалдаанд хэрэглэхийг эсэргүүцээр ирсэн аж. Тухайлбал, АНУ-ын худалдааны төлөөлөгчид Хятадтай хэлэлцээнд ийм байр суурьтай байсныг Crompton зөвлөх фирмийн шинжээч Жюд Бланшет онцлов. Бээжин интернет болон стратегийн салбар дахь гадныхны

оролцоог хязгаарлахдаа үндэсний аюулгүй байдалд дулдуйдаж байв.

Тэгвэл "АНУ одоо үндэсний аюулгүй байдлыг хэтрүүлэн тавих боллоо" хэмээн Бланшет дүгнэсэн байна. Тэрбээр Huawei-н асуудал улам хурцдсан нь хэлэлцээний тасалдал ойрын үед шийдэгдэх шинжгүйг харуулж байна гэжээ. Трампын захиргаа эхний өдрөөсөө л АНУ-д хэтэрхий удаан хохирол учруулсан худалдааны шударга бус байдлыг халахаа мэдэгдсэн. Өнгөрсөн сард Цагаан ордны зөвлөх Питер Наварро Харвардын их сургуульд хэлсэн үгэндээ Вашингтон Хятадын эдийн засгийн зөрчилтэй загвар болон Герман мэт улсын худалдааны заль мэхийг эсэргүүцэх болно хэмээн онцолсон юм.

Энэ нь ноён Трамп тус улсын автомашин импортыг хязгаарлах бай болгож буйг хэлсэн бололтой. Тэрбээр "Америк эдийн засгийн түргэн өсөлтийг хэрхэн хангах талаар өглөө бүр бодож сэрдэг Ерөнхийлөгчтэй байгаа нь сайн хэрэг. Америкуудад ажлын байр бий болгохын сацуу үндэсний аюулгүй байдлыг хамгаална" хэмээн мэдэгдсэн.



ЭНЭТХЭГИЙН АВЛИГАЖСАН СОНГУУЛЬД НЭРГҮЙ МӨНГӨ ЦУТГАЖ БАЙНА

Жанет Родригес

Энэтхэгийн сонгууль дэлхийд хамгийн өндөр үнэтэй тооцогдоно. OpenSecret.org-ын мэдээгээр долоон тэрбум ам.доллар зарцуулж байгаа нь 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн 6.5 тэрбумын зардлаас давсан. Түүнчлэн хамгийн их авлигажсан сонгууль болж байгаа гэнэ. Тухайлбал, компаниуд нэрээ нууцлан бэлэн мөнгөний хандив өгч байгааг шинжээчид тэмдэглэв. Компани буюу хувь хүмүүс 14-142000 ам.долларын чекийг Энэтхэгийн улсын банкнаас худалдан авч аль нэг намд нэрээ бичилгүй хандивлахад түүнийг нь банк бэлэн мөнгөөр сольж өгдөг байна. Ийм хэлбэрийн хандиваар намууд 567 сая ам.доллар бэлгэнд авчээ.

Японд 75 насныхан ажиллах нь хэвийн үзэгдэл болж магадгүй

Эми Нобухиро

75 настайдаа Микико Кузуно халагдсан боловч Токиогийн ойролцоох үйлдвэрт ажилд орох өргөдлөө өгчээ. Тэрбээр өргөдлөө биеэр аваачиж өгөхийг илүүд үзсэн байна. Хатагтай Кузуно "Би тэдэнд өөрийгөө ямар эрүүл байгааг харуулахыг хүссэн юм. Миний насны зарим хүн доройтдог шүү дээ" хэмээв. Одоо 78 хүрч буй тэрбээр Вараби дахь жижиг үйлдвэрт гурав дахь жилдээ ажиллаж, угаалга болон чийгтэй алчуур савлах дамжлага дээр ажиллаж байна.

Ийм байдал Японд улам хэвийн үзэгдэл болж, 70-аас дээш насныхны ажил эрхлэлт хөдөлмөр ард түмний шинэ төрхийг илэрхийлж магадгүй. Ерөнхий сайд Шинзо Абэ хатагтай Кузуно мэтийн хүмүүсийг татвар төлөгчөөр үлдээж, Засгийн газрын зардлын ачааллыг аль болох удаан хөнгөвчлөхийг

эрмэлзэж байгаа юм. Япон улсын хүн ам дэлхийд хамгийн түргэн насжиж байгаа нь ил үзүүлэлт.

Үүнийг дагаад нийгмийн халамжийн зардал хурдан өсөж, гуравдугаар сард төгссөн санхүүгийн жилийн байдлаар улсын төсвийн бараг гуравны нэгийг эзэлж байгаа аж. Иймээс Ерөнхий сайд Абэ кампаниудад тэтгэврийн насыг халах болон 70-аас дээш насныхны ажилд нь үлдэх гэх мэт бусад арга хэмжээ авахыг даалгасан хуулийн төсөл санаачилжээ. Шинэ төсөлд ийм арга хэмжээг заавал хэрэгжүүлэхээр тусгасан байна. Түүнчлэн 75 нас хүртлээ тэтгэвэр авахаа хойшлуулахыг дэмжсэн зохицуулалт хийх боломжийг судалж байгаа аж.

Хүн амд эзлэх 65 бас түүнээс дээш насныхны тоогоор Япон дэлхийд тэргүүлдэг агаад насалтаар Швейцарын хамт нэгдүгээр байрт бичигддэг



гэж Дэлхийн банкны мэдээнд дурдсан байна. Төрөлт буурч буй учир Японы хүн ам 2060 он гэхэд гуравны нэгээр цөөрч, 40 хувь нь 65-аас дээш насныхан болох төлөвтэй байгааг тус улсын Хүн ам, нийгмийн хангамжийн

хүрээлэнгээс мэдээлэв.

Либерал ардчилсан намын хууль тогтоогч, 38 настай Шинжиро Койзүми Bloomberg-т өгсөн ярилцлагадаа "Бид эдийн засгийн бүтцээ 100 наслах амьдралын загварт зохицуулан

өөрчлөх хэрэгтэй байна. Энэ бол бидний эн тэргүүний асуудал бөгөөд нийгмийн халамжийг шинэчлэлийг өөрчлөхгүйгээр дараа үеийнхний ирээдүйг хангаж чадахгүй" хэмээн тайлбарлав. Хүмүүсийг дахиад хэдэн жил ажиллахыг ятгах нь хүндрэлтэй байж болзошгүй гэж тэрбээр нэмж өгүүлэв.

Сүүлийн санал асуулгаас үзэхэд хүмүүсийн 38 хувь нь 65 наснаасаа хойш ажиллахыг хүсэж байгаа бол 50 гаруй хувь нь уг насанд хуралгүй ажиллах хүчнээс хасагдах бодолтой байгааг харуулав. Хүч хөдөлмөр шаарддаг барилга, асаргаа, үйлчилгээ гэх мэт салбарт ажиллах хүчин дутагдалтай байдаг. Түүнчлэн насжилт хамгийн өндөр хөдөө нутагт 65 ба дээш насныханд тохиромжтой ажлын байр хомсоджээ. Настнуудын ажиллах боломжийг нэгчдийн нэг нь Tempres холдингийн захирал, 72


настай Ацуши Моришита юм. Түүний компани гал тогооны хэрэгслийн 58 сүлжээ дэлгүүртэй бөгөөд 90 гартлаа фермд дараа үеийнхний ирээдүйг хангаж авч тэтгэвэрт суухыг яарахгүй байгаа гэнэ.

Тэрбээр "Токиод хүмүүс 65 гараад л бөмбөг мэтийг тоглож цагаа өнгөрөөдөг. Би тэднийг ажлын байраар хангахыг хүсэж байна" хэмээв. Тэдний компанид ажиллагсдын дөрөвний нэг нь 60-аас дээш насныхан байна. Ноён Моришита настай ажилчдын хөдөлмөрийн бүтээмж доогуур байдаг учир цалин ба бүтээгдэхүүний хэмжээг зохицуулах хэрэгтэйг үйлдвэрийн эзэд мэдвэл зохино хэмээсэн юм. "Toyota мэтийн өндөр шаардлагатай газар тэд ажиллаж чадахгүй. Харин манайх шиг эрч султай газар алдагдалд орохгүй" гэж ноён Моришита ярилаа.

Эдийн засаг

Сэтгүүлийн зохиолчид “үнэд орлоо”

Холливудын студиуд худалдан авдаг сэтгүүлийн материалын тоо сүүлийн арван жилд өсөх хэрээр үнэд оров.



Шоу эрхлэгчдийн үнэ өсөж, сайн зохиолчид дутагдаад ирмэгц студиуд сэтгүүлчдийн бүтээлийг шоу болгох нь эрс ихэслээ.

Лукас Шоу

Сэтгүүлдэд бүтээлээ хэвлүүлдэг Дэвид Кушнерын аялал олон янз. Тэрбээр Wired сэтгүүлийн төлөө Москвад сансрын нисгэгчийн бэлтгэл хийж, Outside сэтгүүлийн захиалгаар Анкоридэд мөстэй водка савлаж байсан сэтгүүлч хүн. Саяхнаас ажил нь Кушнерийг тийм ч сонин бус чиглэл болох Холливуд руу хөтөлдөг боллоо.

Кушнер 2002 онд Masters of Doom анхны номоо хэвлүүлснээс хойш BBC, A24 кино студи, Netflix зэрэг төрөл бүрийн энтертэймент компаниудад 15 төслөө зараад байна. Тэрбээр өнгөрсөн өвөл стиминг үйлчилгээний Hulu компанид хуучин материалуудаа ТВ шоу болгох, шинэ бүтээлүүдтэй нь эхэлж танилцах эрхийг зарсан юм. Өдгөө Hulu-гийн удирдлага Кушнерын бүтээлүүдэд телевизийн цуврал хийчих санаа үлдсэн эсэхийг судалцаж байна.

“Одоо бол бүх юм кино студид зохиолчтой байгуулах гэрээ болсон. Стивен Кингийн дараа би л Холливудтай хамгийн их гэрээ байгуулсан зохиолч болж буй бололтой” хэмээн тэрбээр өгүүлэв.

Бөөн мөнгө хийж буй зохиолч ганц Кушнер ч биш юм. Гялгар сэтгүүлдүүдийн нийтлэлч байсан Крис Жонс Netflix-ийн Away хэмээх сансрын цуврал драмыг бичиж өгч байгаа. Тэрбээр уг цувралын зохиолыг Esqire сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллэгтээ тулгуурлаж бүтээсэн юм. Мөн сэтгүүлч Мишел Дин BuzzFeed сэтгүүлд хэвлүүлсэн гэмт хэргийн тухай материалдаа тулгуурлан Hulu-д зохиолч, шоу эрхлэгчээр ажиллаж байна.

Сэтгүүлд юм бичдэг хүн өдгөө “ховордсон амьтан” болж байна. Гэхдээ аз түшсэн зарим нь Peak TV гэгдэж буй өвөрмөц үзэгдлийн үр шимийг хүртэж шоу эрхлэгч, жүжигчин, стилист,

уран бүтээлийн багийн гишүүн, контент нийлүүлэгч болох замаар ажил мэргэжлийнхээ царааг өргөтгөж чадав.

Netflix, Amazon, Apple, Walmart зэрэг гүнтгэр гүрийвчтэй компани айл гэрийн энтертэйментээр уламжлалт медиа конгломе-

ратуудтай ширүүн өрсөлдөх боллоо. Шинэ үеийн аваргууд өвөрмөц содон шийдэлтэй шоу хөтөлбөрүүдийг тусгайлан захиалдаг болсон нь телевизийн шоу салбарыг хямрааж орхив. Зөвхөн 2018 оны байдлаар захиалгат зохиолоор бүтээсэн

телевизийн шоу бараг 500-д хүрч, арван жилийн өмнөх үеийнхээс хоёр дахин өссөнийг кабелийн сүлжээний FX компанийн статистик харуулж байна.

Сэтгүүлд нийтлэгдсэн материалыг телевизийн студи, стриминг үйлчилгээний ком-

паниуд худалдаж авах нь ихэссэнээс үнэ нь өссөөр байна. Урьд нь телевизийн студиуд 5,000-10,000 ам.доллараар худалдаж авдаг байсан материалууд өдгөө 20,000-50,000 ам.долларын үнэтэй болжээ. Тэр ч байтугай зарим нь 100,000 ам.доллар

хүрсэн тохиолдол ч бий. Ердөө хэвлэлд нийтлэгдсэн материалыг телевизийн шоу болгох эрхийн үнэ шүү дээ.

Студи төсөл хэрэгжүүлэх тохиолдолд зохиолчид төлөх үнэ буюу худалдан авах үнэ 350,000-1,000,000 ам.доллар болдгийг уг салбарт мэргэжсэн арав гаруй захирал тайлбарласан юм.

AT&T, Walt Disney, Apple-ын стриминг үйлчилгээ зах зээлд нэвтрэх хэрээр энэ үнэ улам өсөх төлөвтэй. Зарим шинэ сервис хэдийн хуучин санааг шинээр хөгжүүлээд эхэлчихлээ. Apple Inc урьд нь Epic Magazine-д нийтлэгдсэн хэд хэдэн өгүүллэгт тулгуурлан Little America хэмээх цуврал бүтээж байна.

Уран бүтээлийн гараагаа сэтгүүл зүйгээс эхэлж Epic сэтгүүлийг 2013 онд үндэслэсэн сэтгүүлч Жош Дэвис, Жошуа Берман нар Холливудын үйлдвэрлэлд нэвтэрч цуврал бүтээлийн продюсерүүд болцгоов. NBC Universal-ын дэмжлэгтэй Vox Media компани үнийн дүнг нь нийтэд зарлаагүй хэлцлийнхээ дагуу Epic-ийг худалдан авч байгаагаа дөрөвдүгээр сард зарласан билээ.

Саяхан болтол студиуд non-fiction буюу бодит явдалд тулгуурлан бүтээл туурвидаг зохиолчидтой харьцах нь ховор байлаа. Гэтэл шоу эрхлэгчдийн үнэ өсөж, сайн зохиолч дутагдаад ирмэгц студиуд сэтгүүлчдийн бүтээлийг шоу болгох нь эрс ихэслээ.

Кушнерт одоогоор Лос-Анжелес явах төлөвлөгөө байхгүй ч санаа нь хэдийн хувираад эхэлчихсэн. “Сэтгүүл, номыг алгасаад шууд телевизэд зориулж буй хэд хэдэн төсөл дээр ажиллаж байгаа”-гаа тэрбээр тайлбарласан юм. Магадгүй үнэн түүх хүүрнэхийн тулд заавал сэтгүүлд гаргаж, ном хэвлүүлэх шаардлагагүй болох нь.

Корнелийн их сургуулийн профессор өөрийн гэсэн криптовалют гаргалаа

Эмин Гюн Сирер Нью-Йорк хотноо чуулсан Token Summit-дээр үг хэлж байгаа нь.



Ольга Хариф

Блокчэйн технологийн шилдэг экспертүүдийн нэг Эмин Гюн Сирер мэргэсэн салбарынхаа тэргүүлэх венчур капиталистуудын санхүүжилтээр өөрийн гэсэн криптовалютыг сүлжээнийх нь хамт ашиглалтад орууллаа.

Ава сүлжээ нь өгөгдлийг өргөн зурвасаар нэвтрүүлж, транзакцийг шуурхай баталгаажуулах, хангамжийн сүлжээнээс эхлээд үнэт цаас, алтны үнэ хянадаг төрөл бүрийн программыг дэмжиж ажиллах чадвартайг Корнелийн их сургуулийн Криптовалют, Ухаалаг Гэрээний Санаачилгын захирал Сирер тайлбарлав.

Өнөөгийн олон блокчэйн сүлжээ тусгай төрөлжсөн, хэрэглэгчийн хувийн өгөгдлийн халдашгүй байдлыг сахиж, үнэ цэн хадгалахад илүүтэй анхаардаг. Тэгвэл Ava нь Visa-тай адилар нэг секундэд олон

транзакц боловсруулж, гүйлгээг 1.35 секундэд баталгаажуулдаг учраас ямар ч хэрэглэнд, тэр ч байтугай одоохондоо боломжгүй гэгдэж буй гүйлгээнд хүртэл тохирно гэж захирал өгүүлсэн юм.

“Нэг өдөр үнэт цаас болгоныг блокчэйнээр төлөөлүүлдэг болно” хэмээн 47 настай Сирер үзэж байна. “Ам.долларын дэвсгэрт болгон блокчэйн болно. Чухам ийм юм бий болгох үндэс суурийг бид бүрдүүлэхээр зорьж байгаа” хэмээн тэрбээр өгүүлэв. Хоёрдугаар сараас хойш Andreessen Horowitz, Polychain, MetaStable зэрэг компаниас зургаан сая ам.долларын хөрөнгө төвлөрүүлдэг байгаа Сирерийн Ava Labs Inc хэмээх старт-ап сүлжээнийхээ туршилтыг нэрвэ гарагт эхэллээ. Уг сүлжээ хэдэн долоо хоногийн дараа нийтэд нээлттэй болмогц виртуал валют гаргах юм.

Ava Labs нь Team Rocket

Avalanche протокол нь Bitcoin-ыхоос илүү уян хатан, хүчирхэг ажиллагаатай хэмээн Сирер тайлбарлав.

халхавч нэртэй группээс анх үүсгэсэн транзакц шалгах шинэ төрлийн Avalanche хэмээх хуваарилалттай протоколыг боловсруулан хөгжүүлэгч. Avalanche протокол нь Сатоши Накамото хэмээх халхавч нэртэй үл мэдэгдэх хувь хүн, группийн үүсгэж хөгжүүлсэн Bitcoin протоколоос илүү уян хатан, хүчирхэг ажиллагаатай хэмээн Сирер тайлбарлаж байна.

Шинэ Ava-г ширүүн өрсөлдөөн хүлээж байна. Одоогийн дийлэнх блокчэйн сүлжээ техник үзүүлэлт, чадварын хувьд Ava-гаас хавьгүй сул боловч Ethereum зэрэг олон платформ ирэх хэдэн сард сүлжээгээ сайжруулж транзакцийн хурдаа эрс ихэсгэхээр ажиллаж байна. Ava нь том корпорацуудтай түншилж, хотуудад сүлжээгээ нэвтрүүлэх замаар дэлхий даяар үйл ажиллагаагаа өргөтгөхөөр төлөвлөж байгааг тэрбээр мэдэгдлээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт” /БГД, 17 дугаар хороо/-ын ажил
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/074
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос “Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт” /БГД, 17 дугаар хороо/-ын ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.
 Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.
 Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.
 Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо: Сүүлийн 2 жилийн (2017, 2018 он) борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.
Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд хуулбарлан ирүүлнэ.
Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:
1.2.1.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө,

тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш эсвэл

3Т-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) болон түүнээс дээш.

1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв болон түүнээс дээш эсвэл

3Т-11.3 Барилга байгууламжийн засварын ажлын төсөв болон түүнээс дээш.

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт болон түүнээс дээш, эсвэл

БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил болон түүнээс дээш.

Тендерийн хамт **1,000,000 /нэг сая/** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна


Тендерийг **2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө** системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 7575 7810

Эдийн засаг



С.Батсайхан / ЗГМӨ

ШИЛ ҮЙЛДВЭРЛЭЛД ШИНЭ БОЛОМЖ НУУГДАЖ БАЙНА

Шил, шилэн эдлэлийн импорт даган багагүй хэмжээний валют хилийн чанад руу урсгаж байна

Г.Байгал
@baigalZGM

Таны ундааг нь уугаад хаясан лонх ам.долларын ханшийг өсгөдөг. Итгэмээргүй бас инээд хүрмээр сонсогдож болох ч энэ бол бодит үнэн. Учир нь хүн амын хэрэглээнд жин дардаг шил, шилэн эдлэлийн дотоодын зах зээлд импортын түүхий эд, бүтээгдэхүүн ноёлоор байгаа юм. Нийслэлийн төвд сүндэрлэж буй гял цал, гоёмсог байшингийн фасадаас эхлээд барилгын цонх, аяга шаазан, нүдний шил, гэрлийн чийдэн, ус ундааны лонх гээд монголчуудын шилний хэрэглээ жилээс жилд нэмэгдсээр байна. Өмнө нь голдуу ахуйн хэрэглээнд эрэлттэй байсан энэ төрлийн бүтээгдэхүүн эдүгээ барилга, бүтээн байгуулалтын гол түүхий эдийн нэг болж, бидний хэрэглээ улам төрөлжжээ. Гэхдээ энэ өсөлт, өөрчлөлтийг даган Монголоос гарах валютын урсгал урам эрчимжсээр байгаа юм.



Гаалийн ерөнхий газрын мэдээллээр Монгол Улс энэ төрлийн бүтээгдэхүүнийг хилийн чанадаас худалдан авахад ойролцоогоор 150 орчим тэрбум төгрөг зарцуулдаг байна. Хэрэглээ нь солонго адил олон салбарт салаалдаг шил, шилэн эдлэлийн импорт даган ийнхүү багагүй хэмжээний валют хилийн чанад руу гадагшилж, Монгол Улсын урсгал тэнцэл уруудах, ам.долларын ханш өсөх нэг шалтгаан болж буйг банкны салбарынхан хэлдэг юм.

Шил авахаар урсгаж буй нийт валютын талаас илүүг нь ахуйн хэрэглээний буюу лонх, сав, вааранд зарцуулдаг байна. 2018 оны байдлаар

Монгол Улс 118 сая ширхэг шилэн лонх, сав, ваарыг нийт 33 сая ам.доллараар худалдан авчээ. Үүн дээр нэмээд барилга, бүтээн байгуулалтын зориулалт бүхий шилний эрэлт сүүлийн үед эрчтэй өссөн. Шилээр хот сүндэрлүүлэх дэлхийн барилгын шинэ хандлага Монгол Улсыг ч дайрч, томоохон хотуудын төвд хаашаа л харна шил толь болсон өндөр цамхгууд нүд гялбах болсон. Монгол Улс энэ төрлийн барилгын материалын түүхий эдэд ойролцоогоор 12 сая ам.доллар зарцуулдаг аж. Ингээд зогсохгүй гоёл чимэглэл, дохиоллын шилэн зүйлс, чийдэнгийн шил гээд бидний амьдралын салшгүй хэрэглээ болсон шилэн зүйлс мундахгүй. Наанадаж л зун, хаврын энэ хавсаргатай өдрүүдийг нүдний шилгүйгээр туулах улам амаргүй болж буй.

Бидний тэр бүр анзаардаггүй ч амьдралын олон талт хэрэглээ болсон шилний зах зээлд эргэлдэх мөнгө тогтвортой өссөөр байна. Сүүлийн жилүүдэд шилэн фасадны эрэлт өссөнөөр дотоодын хэд хэдэн үйлдвэр энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхэлжээ. Тухайлбал, орон сууцны цонх, шилэн фасад, шилэн хийцүүдийг хийж байгаа “Шилэн хийц”, “Макс шил”, “Шилмэл шил” зэрэг 10 гаруй компани үйл ажиллагаа явуулж байна. Гэхдээ гол түүхий эд болох шилээ бүгд гадаадаас импортоор авч, эх орондоо боловсруулж буй. Учир нь энэ төрлийн үйлдвэрлэл хүний амь нас, эрүүл мэндтэй нягт холбоотой тул чанар, аюулгүй байдал нэн тэргүүнд тавигддаг. Тиймээс өндөр стандартын шаардлага хангасан түүхий эдийг үйлдвэрлэлдээ ашиглахыг илүүд үздэгээ дотоодын компаниуд учирладаг.

Харин лонхны үйлдвэр тун ховор байна. Уг нь социализмын үед Налайхад шилний үйлдвэр ажилладаг байлаа. Хэдийгээр уг үйлдвэрийн бүтээгдэхүүн, үзэмж, чанараар өндөр байгаагүй ч дотоодын шилэн сав суулганыхаа хэрэгцээний



● Шил авахаар урсгаж буй нийт валютын талаас илүүг нь ахуйн хэрэглээний буюу лонх, сав, домбо, вааранд зарцуулдаг байна.

● 2018 оны байдлаар Монгол Улс 118 сая ширхэг шилэн лонх, сав, домбо, ваарыг нийт 33 сая ам.доллараар худалдан авдаг байна.

● Сүүлийн жилүүдэд шилэн фасад эрэлт өссөнөөр дотоодын хэд хэдэн үйлдвэр энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлжээ.

дорвитой судалгаа ховор байна. Учир нь энэ чиглэлээр судалгаа хийх лаборатори, техник тоног төхөөрөмж сул юм.

Иймд гудамжинд хөглөрч, хогийн цэгүүдэд төвлөрдөг лонх болон бусад шилэн эдлэлүүдийг дахин боловсруулах нь хамгийн боломжит гарц аж. Хаягдал шилийг буталж элс болгоод, шохойн чулуутай хольж, тусгай барьцалдуулагчаар бэхжүүлэн, импорт орлох хиймэл чулуун тавцан хийсэн туршлага, технологи, тоног төхөөрөмжийг иргэд, аж ахуйн нэгжүүд оруулж иржээ. Гэвч түүхий эдээ татан төвлөрүүлэх тогтолцоо бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас үйлдвэрлэл нь зогсонги байна.

Харин өнгөрсөн оны сүүлчээр “Наран туул Трейд” компани Итали, Германы компанитай хамтран хоногт 90 тонн шил хайлуулах хүчин чадалтай, шилэн лонхны цогц үйлдвэр ашиглалтад оруулахаар зорьж байгаа аж. Төлөвлөгөөний дагуу уг үйлдвэр 2020 он гэхэд анхны бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэхийг тус компани мэдээлсэн. Нэг хүнд ногдох согтууруулах ундааны үйлдвэрлэл, хэрэглээгээрээ дэлхийд дээгүүрт бичигддэг Монгол Улсад ахуйн хэрэглээний шил, шилэн эдлэл боловсруулах үйлдвэр тул шаардлагатай.

Бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд зэс боловсруулах, нефть нэрэх зэрэг том том үйлдвэр мөрөөдсөөр ирсэн атлаа эх орны эдийн засаг болон иргэдийн амьдрал нэн чухал үүрэгтэй шил, барилгын материалын үйлдвэрлэлийг тэр бүр чухалд тооцож, төрийн бодлогоор дэмжиж байсангүй. Биднийг том том төслүүд ярьж, хоосон мөрөөдсөөр суух зуур энэ чиглэлийн үйлдвэрлэл, зах зээл мартагдаж, бизнесийн утгаар урагшилж чадахгүй болох нь.

Хэдийгээр шил, шилэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зах зээлийн хэмжээ, хөрөнгө оруулалтаар хүнд үйлдвэрлэлтэй харьцуулахад бага боловч Монголын эдийн засаг, гадаад

худалдаанд үзүүлж буй нөлөө нь чамлахааргүй юм. Бидний хог болгоод хаячихдаг шил, шилэн бүтээгдэхүүний цаана өндөр өсөлт, бизнесийн таатай боломж нуугдаж байна.

Дэлхий даяар хүн амын эрүүл мэнд, экологийн тэнцвэрт нэн халтай хуванцраас татгалзах хандлага газар авч буй энэ үед шилэн эдлэлийн хэрэгцээ ирээдүйд өсөх нь ойлгомжтой. Тиймээс ахуйн хэрэглээний шилний үйлдвэрийг сэргээх шаардлага тулгарсаар байна.

Нөгөө талд, зуу хүрэхтэй

Монгол Улс шил, шилэн эдлэлийн импортод ₮150 орчим тэрбумыг зарцуулдаг

үгүйтэй жилийн хугацаанд суурин иргэншилд шилжиж буй монголчуудын хотжилт энэ зуунд үргэлжилж, энэ хэрээр барилга, бүтээн байгуулалтын түүхий эдийн эрэлт өсөх нь ойлгомжтой. Энэ нь ирэх жилүүдэд ч барилгын салбарт ашиглах гадна, дотор фасад болон цонхны шилний эрэлтийг өндөр хэвээр хадгалах нь ойлгомжтой. Үүнээс үзэхэд ахуйн болон бусад шил, шилэн эдлэлийн эрэлт өсөх нь тодорхой.

Энэ салбарыг татварын болон бусад бодлогоор дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хөл дээр нь зогсоох болон шилэн эдлэлийн түүхий эдийн хайгуул, судалгааг эрчимжүүлэх шаардлага байна. Ингэснээр Монгол Улсад импорт орлох дотоодын үйлдвэрлэлийг цогцлоож, ажлын байрыг нэмэгдүүлэх сайн талтай. Цаашлаад жил бүр хилийн чанад руу сая саяар нь шилжүүлдэг валютын урсгалыг дотооддоо нь тогтоож, ам.долларын ханшийн өсөлтөд хаалт тавих юм. [ЗГМӨ]

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.38%	0.58%	0.07%	0.89%	1.09%	2.48%	1.16%	0.58%